



## ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХХК

12 дугаар сарын 31-ний өдрөөр  
дуусгавар болсон тайлант жилийн  
**САНХҮҮГИЙН ТАЙЛАН**  
(Хараат бус аудиторын тайлангийн хамт)

# 2017

## Агуулга

	Хуудас
Банкны Мэдээлэл	1
Удирдлагын Хариуцлагын Мэдэгдэл	2
Хараат Бус Аудиторын Тайлан	3-5
Ашиг, Алдагдал болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын Тайлан	6
Санхүүгийн Байдлын Тайлан	7
Өмчийн Өөрчлөлтийн Тайлан	8
Мөнгөн Гүйлгээний Тайлан	9
Санхүүгийн Тайлангийн Тодруулга	10

## Тээвэр Хөгжлийн Банк ХХК

### Банкны Мэдээлэл

Албан ёсны хаяг	Монгол улс, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Олимпийн гудамж, Шангрилла оффис, 15 дугаар давхар, Тээвэр Хөгжлийн Банк ХХК
Хувьцаа эзэмшигч	М. Тэмүүжин (68%) Д. Оюунгэрэл (13.49%) Л. Болд (10.35%) Инфраструкчер ХХК (8.16%)
Төлөөлөн Удирдах Зөвлөл	О. Энхбаяр Т. Пүрэвдорж Д. Дашчойнхор Б. Мөнхзаяа Д. Түмэнжаргал
Гүйцэтгэх захирал	М. Отгонбаяр
Хараат бус аудитор	Кэй Пи Эм Жи Аудит ХХК Монгол улс, Улаанбаатар-14240, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө 17, Блю Скай цамхаг, 602 тоот

## УДИРДЛАГЫН ХАРИУЦЛАГЫН МЭДЭГДЭЛ

Банкны удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Тээвэр Хөгжлийн Банк ХХК (цаашид “Банк” гэх)-ийн санхүүгийн тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэгдсэн. Удирдлага нь энэхүү санхүүгийн тайлан нь Банкны 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг үнэн зөв илэрхийлсэн болохыг баталгаажуулах үүрэгтэй.

Банкны удирдлага нь Банкны санхүүгийн тайланг тодруулга 2 ба 3-т дурдсан шаардлагуудад нийцсэн гэдгийг баталгаажуулах боломжийг хангах, санхүүгийн байдлыг үндэслэлтэй, үнэн зөвөөр илэрхийлж чадах зөв зохистой нягтлан бодох бүртгэлийг хөтөлж бэлтгэсэн гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

Мөн удирдлага нь Банкны эд хөрөнгийг хадгалан хамгаалах, аливаа залилан ашиглал, зүй бүс үйлдлээс сэргийлэх, ийм үйлдэл гарвал илрүүлэхэд шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх ерөнхий үүрэгтэй.

Банкны удирдлага нь 6-60 дугаар хуудсанд илэрхийлсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ тохиромжтой нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгон, тууштайгаар даган мөрдөж, үндэслэлтэй, нягт нямбай тооцоолол, үнэлгээ хийн, холбогдох бүх нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдсөн гэж үзэж байна.

Банкны удирдлагаас Тээвэр Хөгжлийн Банк ХХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайланг зөвшөөрч батлав.



М.Отгонбаяр  
Гүйцэтгэх Захирал



Ч. Сайнбилэг  
Санхүү Эрхэлсэн Дэд Захирал

Монгол Улс,  
Улаанбаатар хот

2018 оны 02 дугаар сарын 14-ний өдөр



Кэй Пи Эм Жи Аудит ХХК  
Монгол Улс, Улаанбаатар-14240,  
Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо,  
Энхтайваны өргөн чөлөө 17,  
Блю Скай Тауэр, 602 тоот

Утас: +976 7011 8101  
Факс: +976 7011 8102  
[www.kpmg.com/mn](http://www.kpmg.com/mn)

## Хараат бус Аудиторын Тайлан

Тээвэр Хөгжлийн Банк ХХК-ийн Хувьцаа эзэмшигчид болон Төлөөлөн Удирдах Зөвлөлд:

### Дүгнэлт

Бид Тээвэр Хөгжлийн Банк ХХК (цаашид “Банк” гэх)-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, мөн нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй болон тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, Банкны санхүүгийн тайлангууд нь 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (“АОУС”)-ын дагуу гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн *Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага* хэсэгт харуулсан. Бид *Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл (“НБЁЗОУСЗ”)*-ийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм болон санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой Монгол Улс дахь ёс зүйн зохих шаардлагуудын дагуу Банкнаас хараат бус байж, НБЁЗОУСЗ-ийн Ёс Зүйн Дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай, зохих үндэслэл болно гэдэгт бид итгэж байна.

### Удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах нь Банкны удирдлагын үүрэг хариуцлага юм. Залилан эсвэл алдааны үлмаас материаллагаар буруу илэрхийлэгдээгүй санхүүгийн тайланг бэлтгэж, үнэн зөв толилуулахтай холбоотой удирдлагын шаардлагатай гэж тодорхойлсон дотоод хяналтууд нь мөн энэхүү хариуцлагад хамаарна.



## **Удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага, үргэлжлэл**

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлагын зүгээс Банкны тасралтгүй үйл ажиллагаа эрхлэх чадамжийг үнэлэн, шаардлагатай гэж үзвэл тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг санхүүгийн тайланд тодруулж, Банкыг татан буулгах юм уу үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан санхүүгийн тайлангаа бэлтгэх үүргийг Банкны удирдлага хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Банкны санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хүлээнэ.

## **Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага**

Санхүүгийн тайлан нь залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй нотолгоог олж авах, бидний дүгнэлтийг агуулж буй аудиторын тайланг танилцуулах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт хэдий ч АОУС-ын дагуу гүйцэтгэсэн аудит нь бүхий л материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдааны улмаас үүсч болох ба дангаараа эсвэл нэгдсэн дүнгээрээ уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах мэдээлэл хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөхөөр хүлээгдэж байвал материаллаг гэж үзнэ.

АОУС-ын дагуу аудитыг гүйцэтгэхдээ мэргэжлийн үнэлэмж, үнэлгээ хийх мөн мэргэжлийн үл итгэх үзлээр хандахыг аудитын ажлын явцад шаарддаг. Бид мөн:

- Санхүүгийн тайланд залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авдаг. Залилан нь хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах зэрэг явдлуудыг агуулсан байдаг тул залилангаас үүсэх материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдааны улмаас үүсэх буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдлээс харьцангуй их байдаг.
- Банкны дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горимыг боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын үндэслэл болон холбогдох тодруулгуудыг үнэлдэг.



### Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага, үргэлжлэл

- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн бид олж авсан нотолгоондоо тулгуурлан Банкны тасралтгүй үйл ажиллагаагаа эрхлэх чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Материаллаг тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл бид аудиторын тайланд санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл энэхүү тодруулга нь хангалтгүй бол дүгнэлтээ хязгаарлах шаардлагатай болдог. Бид дүгнэлтээ аудиторын тайлан гаргах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал нь Банк тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц болон агуулгыг тодруулгуудын хамт үнэлж, санхүүгийн тайлан нь холбогдох ажил гүйлгээнүүд болон үйл явдлуудыг үнэн зөв илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн цар хүрээ, хугацаа болон аудитын явцад илрүүлсэн томоохон асуудлууд, тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг.

### Бусад асуудал – Өмнөх жилийн аудитор

Банкны 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайланг өөр аудитын байгууллага аудитласан ба 2017 оны 3 дугаар сарын 15-ны өдөр зөрчилгүй дүгнэлт өгсөн болно.

*Kai Pi Em Zhi Audit LLC*

Кэй Пи Эм Жи Аудит ХХК  
Монгол Улс, Улаанбаатар хот  
2018 оны 02 дугаар сарын 14-ний өдөр



Энэхүү тайлан нь аудитын тайлангийн өдөр буюу 2018 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөр хүчин төгөлдөр үйлчилнэ. Аудитын тайлангийн өдөр болон энэхүү тайланг хэрэглэх хугацааны хооронд тохиолдож болох аливаа тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдал нь уг санхүүгийн тайлан болон тодруулгад материаллаг нөлөө үзүүлж болох юм. Тиймээс аудитын тайланг хэрэглэгчид нь уг тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдлын нөлөөллийг дээрх аудитын тайланд тусгаагүйг анхаарна уу. Энэхүү тайлан нь зөвхөн Банкны хувьцаа эзэмшигчдэд зориулагдсан болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө үүрэг, хариуцлага хүлээхгүй болно.

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХХК  
 Ашиг, Алдагдал болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын Тайлан  
 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<b>Тодруулга</b>	<b>2017</b>	<b>2016</b>
Хүү болон түүнтэй адилтгах орлого	4	3,504,840	345,725
Хүү болон түүнтэй адилтгах зардал	5	(825,382)	(1,859)
<b>Хүүгийн цэвэр орлого</b>		<b>2,679,458</b>	<b>343,866</b>
Хураамж ба шимтгэлийн орлого	6	94,703	85
Хураамж ба шимтгэлийн зардал	6	(131,864)	(24,318)
<b>Хураамж ба шимтгэлийн цэвэр зардал</b>		<b>(37,161)</b>	<b>(24,233)</b>
Арилжааны цэвэр орлого	7	(102,884)	(174)
Үйл ажиллагааны бусад цэвэр орлого	8	892,212	292,270
<b>Үйл ажиллагааны нийт орлого</b>		<b>3,431,625</b>	<b>611,729</b>
Үйл ажиллагааны зардал	9	(1,797,342)	(800,080)
Үйл ажиллагааны бус зардал	10	(432,579)	(88,030)
<b>Болзошгүй алдагдлын сангийн өмнөх ашиг (алдагдал)</b>		<b>1,201,704</b>	<b>(276,381)</b>
Болзошгүй алдагдлын сангийн нөхөлт / (зардал)	11	993,413	(150,332)
<b>Татварын өмнөх ашиг (алдагдал)</b>		<b>2,195,117</b>	<b>(426,713)</b>
Орлогын албан татварын зардал	12	(245,144)	-
<b>Тайлант жилийн цэвэр ашиг (алдагдал)</b>		<b>1,949,973</b>	<b>(426,713)</b>
<b>Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого (алдагдал)</b>		<b>1,949,973</b>	<b>(426,713)</b>

*Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.*



ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХХК  
Санхүүгийн Байдлын Тайлан  
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх

(Мянган төгрөгөөр)	Тодруулга	2017.12.31	2016.12.31
<b>Хөрөнгө</b>			
Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах	13	91,943,312	162,614
Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	14	431,350	69,352
Санхүүгийн хөрөнгө оруулалт - борлуулах боломжит	15	36,950,057	-
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	16	70,483,771	7,324,725
Үндсэн хөрөнгө	17	1,734,329	740,949
Биет бус хөрөнгө	18	540,031	7,764
Бусад хөрөнгө	19	963,714	400,702
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө	20	-	1,181,325
<b>Нийт хөрөнгө</b>		<b>203,046,564</b>	<b>9,887,431</b>
<b>Эздийн өмч ба өр төлбөр</b>			
<b>Өр төлбөр</b>			
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	21	109,911,583	-
Репө хэлцэл	22	36,940,917	-
Харилцагчдын харилцах, хадгаламж	23	254,343	208,974
Бусад өр төлбөр	24	10,287,878	193,404
Орлогын албан татварын өглөг		228,605	5,146
<b>Нийт өр төлбөр</b>		<b>157,623,326</b>	<b>407,524</b>
<b>Эздийн өмч</b>			
Хувьцаат капитал	25	50,000,000	16,000,000
Бусад нөөцүүд		28,518	44,300
Хуримтлагдсан алдагдал		(4,605,280)	(6,564,393)
<b>Нийт эздийн өмч</b>		<b>45,423,238</b>	<b>9,479,907</b>
<b>Нийт эздийн өмч ба өр төлбөр</b>		<b>203,046,564</b>	<b>9,887,431</b>

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХХК  
 Өмчийн Өөрчлөлтийн Тайлан  
 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

	Хувьцаат капитал (Тодруулга 25)	Бусад нөөцүүд	Хуримтлагдсан алдагдал	Эздийн өмчийн дүн
<b>2016 оны 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл</b>	16,000,000	44,300	(6,137,680)	9,906,620
Тайлант жилийн алдагдал	-	-	(426,713)	(426,713)
<b>2016 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>16,000,000</b>	<b>44,300</b>	<b>(6,564,393)</b>	<b>9,479,907</b>
<b>2017 оны 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл</b>	16,000,000	44,300	(6,564,393)	9,479,907
<b>Нийт дэлгэрэнгүй орлого</b>	-	-	1,949,973	1,949,973
Тайлант жилийн ашиг	-	-	-	-
<b>Эздийн өмчөөр шууд бүртгэгдсэн хувьцаа</b>	34,000,000	-	-	34,000,000
эзэмшигчидтэй хийсэн ажил гүйлгээ	-	(15,782)	9,140	(6,642)
Хувьцаа эзэмшигчийн хөрөнгө оруулалт	-	-	-	-
Бусад хөдөлгөөнүүд	-	-	-	-
<b>2017 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>50,000,000</b>	<b>28,518</b>	<b>(4,605,280)</b>	<b>45,423,238</b>

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Мөнгөн Гүйлгээний Тайлан

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<b>Тодруулга</b>	<b>2017</b>	<b>2016</b>
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
Тайлант жилийн цэвэр ашиг/(алдагдал)		1,949,973	(426,713)
Тохируулгууд:			
Үндсэн хөрөнгийн элэгдэл	9, 17	91,749	60,953
Биет бус хөрөнгийн хорогдуулга	9, 18	126,238	267
Данснаас хассан үндсэн хөрөнгө	10, 17	5,955	77,742
Үндсэн хөрөнгө борлуулсны гарз	10, 17	235,769	-
Өмчлөх бусад хөрөнгө борлуулсны олз	8, 20	(531,459)	-
Хүүгийн цэвэр орлого	4, 5	(2,679,458)	(343,866)
Болзошгүй алдагдлын сангийн (нөхөлт)/ зардал	11	(993,413)	150,332
Орлогын албан татварын зардал	12	245,144	-
<b>Хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлт:</b>			
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	16	(61,845,359)	278,115
Монголбанкинд заавал байлгах нөөц	26	(6,948,953)	(13,071)
Бусад хөрөнгө		(557,973)	(101,339)
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	21	109,911,583	-
Репо хэлцэл	22	36,940,917	-
Харилцагчдын харилцах, хадгаламж	23	45,369	93,578
Бусад өр төлбөр		10,019,294	149,027
Хүлээн авсан хүү		3,167,430	373,165
Төлсөн хүү		(750,202)	(1,859)
Төлсөн орлогын албан татвар		(21,685)	(2,585)
<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>88,410,919</b>	<b>293,746</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
Худалдан авсан үндсэн хөрөнгө	17	(1,921,818)	(110,526)
Худалдан авсан биет бус хөрөнгө	18	(658,505)	(6,747)
Худалдсан үндсэн хөрөнгө	17	591,280	-
Худалдсан өмчлөх бусад хөрөнгө	20	1,712,784	-
Худалдан авсан хөрөнгө оруулалтын үнэт цаас	15	(36,940,917)	-
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>(37,217,176)</b>	<b>(117,273)</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
Энгийн хувьцаа нэмж гаргаснаас орж ирсэн мөнгө	25	34,000,000	-
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		<b>34,000,000</b>	<b>-</b>
<b>Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өөрчлөлт</b>			
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>85,193,743</b>	<b>176,473</b>
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	26	207,448	30,975
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	26	<b>85,401,191</b>	<b>207,448</b>

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

## ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн Тайлангийн Тодруулга

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

### 1. Ерөнхий мэдээлэл

Тээвэр Хөгжлийн Банк ХХК (цаашид “Банк” гэх) нь Монгол Улсад үүсгэн байгуулагдсан, тус улсад үйл ажиллагаа эрхэлдэг хязгаарлагдмал хариуцлагатай компани юм. Банкны үндсэн үйл ажиллагаагаа эрхэлдэг албан ёсны хаяг нь Монгол Улс, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Олимпийн гудамж, Шангрилла оффис, 15 дугаар давхар юм.

Банк нь Монгол улсын Банкны тухай хуулийн дагуу Монголбанкны Ерөнхийлөгчийн 1997 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн тушаалаар банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан. Банк нь 1997 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр Улсын бүртгэлийн албанд бүртгүүлсэнээр 2078201 тоот регистр бүхий 9016001016 дугаартай гэрчилгээ болон арилжааны банкны үйл ажиллагаа эрхлэх 12 тоот тусгай зөвшөөрлийн гэрчилгээ авсан.

Өмнөх хувьцаа эзэмшигчдийн хооронд үүссэн маргаан болон түүнээс үүдсэн Банкны үйл ажиллагааны доголдлуудаас хамааран Монголбанкны Ерөнхийлөгчийн 2013 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/229 дугаар тушаалаар Монголбанкны зүгээс банкны үйл ажиллагааны энгийн эрхийг олгосон. Мөн Банкны үйл ажиллагаа сүүлийн жилүүдэд жигд явагдаагүй, зогсонги байдалтай байсан, хөрөнгийн зохист харьцаа алдагдсан зэргээс шалтгаалан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн А/271 тоот тушаалаар Банкны зарим тусгай зөвшөөрлүүдийг хүчингүй болгосон.

Одоогийн хувьцаа эзэмшигчид 2016 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Банкыг хуучин хувьцаа эзэмшигчдээс худалдан авсан бөгөөд өмнөх хувьцаа эзэмшигчдийн удаан үргэлжилсэн маргаан шүүхийн шатанд шийдвэрлэгдсэн.

2017 онд шинэ хувьцаа эзэмшигчид 34,000,000 мянган төгрөгийн нэмэлт хөрөнгө оруулалт хийж, Банкны дүрмийн санг нэмэгдүүлсэн бөгөөд дахин 22,000,000 мянган төгрөгийн нэмэлт хөрөнгө оруулалт хийх хүсэлтийг Монголбанкинд тавьж 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Монголбанкны зөвшөөрлийг авсан. Банкны зүгээс уг хөрөнгө оруулалтыг хувьцаа эзэмшигчдээс 2018 оны эхний улиралд хүлээн авна гэсэн хүлээлттэй байна.

2017 оны 3 дугаар сараас эхлэн Банк нь Монголбанкнаас тавьсан арилжааны банкны үйл ажиллагааны зохистой шалгуур үзүүлэлтүүдийг хангаж эхэлсэн учир Монголбанкны Ерөнхийлөгчийн 2017 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн А/176 тоот тушаалын дагуу банкны үйл ажиллагааны нэмэлт зөвшөөрлийг олгосон. Банк нь 2018 оны 02 дугаар сарын 14-ний өдөр үлдсэн зөвшөөрөгдөөгүй үйл ажиллагаануудын хувьд нэмэлт зөвшөөрлийг авсан. Банкыг гурван хувь хүн, нэг компани эзэмшдэг ба эцсийн хяналт тавигч этгээд нь ноён М.Тэмүүжин юм.

### 2. Санхүүгийн тайлагналын зарчим

#### *(а) Тайлагналын нийцэл*

Санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын дагуу бэлтгэж тайлагнасан.

## 2. Санхүүгийн тайлагналын зарчим (үргэлжлэл)

### **(б) Үнэлгээний суурь**

Санхүүгийн тайланг холбогдох тодруулгад тусгайлан тодруулснаас бусад зүйлсийн хувьд түүхэн өртгийн зарчимд үндэслэн бэлтгэсэн.

### **(в) Үйл ажиллагааны ба тайлагналын валют**

Энэхүү санхүүгийн тайланг Банкны бүртгэлийн валют болох Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр толилуулсан бөгөөд энэ нь Банкны үйл ажиллагаа явуулж буй гол эдийн засгийн орчны үндсэн валют болно. Тусгайлсан хэсэгт онцлон зааснаас бусдаар санхүүгийн тайланг мянгачилж толилуулсан.

### **(г) Таамаглал, тооцоолол болон үнэлэмжийн хэрэглээ**

Санхүүгийн тайланг СТОУС-д нийцүүлэн бэлтгэх үйл явц нь таамаглал, тооцоолол болон үнэлгээ хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү таамаглал, тооцоолол, үнэлгээ нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт болон бүртгэсэн хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын дүнг тодорхойлоход нөлөөлдөг. Тооцооллыг гаргахад өнөөгийн болон хүлээгдэж буй эдийн засгийн нөхцөл байдал, түүхэн түршлага гэх мэт хүчин зүйлс, мөн олон төрлийн таамаглал дээр суурилсан үнэлэмж гаргахыг шаардаж байдаг. Гүйцэтгэлээрх үр дүн нь эдгээр таамаглал, тооцооллоос ялгаатай байж болно.

Тооцоолол, түүнийг хийхэд хэрэглэсэн гол чухал таамаглал, төсөөллийг байнга хянаж байдаг. Нягтлан бодох бүртгэлийн тооцоололд хийсэн өөрчлөлтийн нөлөөллийг тухайн өөрчлөлт хийгдсэн тайлант жил болон ирээдүйн тайлант жилүүдэд тусгадаг.

#### **(i) Таамаглал болон тооцооллын тодорхойгүй байдал**

Дараагийн санхүүгийн жилд материаллаг залруулгад хүргэж болох нөлөөлөхүйц эрсдэлтэй тооцоолол болон таамаглалын тодорхойгүй байдлын талаарх мэдээлэл дараах тодруулгуудад орсон болно:

- (а) Хүүгийн орлого хүлээн зөвшөөрөлт – Тодруулга 3 (й);
- (б) Санхүүгийн ба санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт – Тодруулга 3 (ё), (ж);
- (в) Борлуулах боломжтой хөрөнгө оруулалтын үнэт цаас;
- (г) Үндсэн хөрөнгийн ашиглагдах хугацаа – Тодруулга 3 (д);
- (д) Биет бус хөрөнгийн ашиглагдах хугацаа – Тодруулга 3 (е).

#### **(ii) Бодит үнэ цэнийн хэмжилт**

Банк нь хөрөнгө болон өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлохдоо тухайн зах зээл дээрх хамгийн сайн ажиглагдахуйц мэдээллийг ашиглахыг зорьдог. Бодит үнэ цэнийг үнэлгээний арга барилд ашиглагдах өгөгдлүүдээс нь хамааруулан дараах шатлалаар ангилдаг:

## 2. Санхүүгийн тайлагналын зарчим (үргэлжлэл)

- Түвшин 1: ижил төстэй хөрөнгө эсвэл өр төлбөрийн идэвхтэй зах зээлийн жишиг үнэ  
Түвшин 2: тухайн хөрөнгө, өр төлбөрийн хувьд 1 дүгээр түвшинд багтсан жишиг үнээс бусад өгөгдлүүд, шууд эсвэл шууд бусаар  
Түвшин 3: хөрөнгө эсвэл өр төлбөрийн зах зээлийн ажиглагдахуйц мэдээлэл дээр суурилагагүй өгөгдлүүд

Хэрэв хөрөнгө эсвэл өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлоход бодит үнэ цэнийн ялгаатай шатлалууд дамжсан мэдээллүүдийг ашигласан бол Банк нь хөрөнгө эсвэл өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлоход гол нөлөөлсөн өгөгдлийн бодит үнэ цэнийн шатлалын хамгийн доод түвшнээр тодорхойлох ба бодит цэнийн үнэлгээний шатлалын хооронд шилжилт гарсан тохиолдолд тайлант үеийн эцэст эдгээр шилжилтүүдийг хүлээн зөвшөөрдөг.

(iii) Тасралтгүй байх зарчим

Санхүүгийн тайланг удирдлага зохистой гэж үзсэний дагуу тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэсэн.

## 3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд

Банк нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн дараах хураангуйлсан үндсэн бодлогуудыг баримталсан ба эдгээр нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь тайланд тусгагдсан бүх жилүүдэд тогтвортойгоор хэрэглэгдсэн болно.

### **(а) Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээ**

Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө болон өр төлбөрийг тайлагналын өдрийн хаалтын ханшаар үйл ажиллагааны валют руу хөрвүүлэн илэрхийлдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн ба бодит үнэ цэнээрээ хэмжигдсэн мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрийг уг бодит үнэ цэнийг тодорхойлсон өдрийн албан ханшаар үйл ажиллагааны валют руу хөрвүүлэн илэрхийлдэг.

Борлуулах боломжтой өмчийн хэрэгслүүд дээрх валютын хөрвүүлэлтийн зөрүүнээс бусад гадаад валютын дахин хөрвүүлэлтээс үүссэн ханшийн зөрүүг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг. Гадаад валютаарх түүхэн өртгөөрөө хэмжигдсэн мөнгөн бус зүйлсийг ажил гүйлгээ гарсан өдрийн валютын ханшаар тайлагнадаг.

Харин, борлуулах боломжтой өмчийн хөрөнгө оруулалтын хөрвүүлэлтээс үүссэн гадаад валютын ханшийн зөрүү (үнэ цэнийн бууралтаас бусад тохиолдолд гадаад валютын ханшийн зөрүүг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрч ашиг, алдагдал руу дахин ангилна)-г бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг.

### 3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

#### (б) Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөр

##### i. Хүлээн зөвшөөрөлт

Банк зээл ба урьдчилгаа, хадгаламж, гаргасан өрийн үнэт цаас, хоёрдогч өр төлбөр зэргийг үүссэн өдрөөр нь анх хүлээн зөвшөөрнө. Бусад бүх санхүүгийн хэрэгслүүд (санхүүгийн хөрөнгийн тогтмол худалдан авалт, борлуулалтыг хамруулаад)-ийг Банк гэрээний дагуу үүрэг хариуцлага хүлээх болсон үеэс буюу арилжаа хийгдэх үед хүлээн зөвшөөрнө.

Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдэхээс бусад санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдийг анхлан бодит үнэ цэнээр нь бүртгэх ба худалдан авах эсвэл гаргахтай шууд холбоотой гарсан зардлыг нэмж бүртгэнэ.

##### ii. Ангилал

###### Санхүүгийн хөрөнгө

Банк нь санхүүгийн хөрөнгийг дараах төрлүүдэд ангилдаг:

- Зээл ба авлага;
- Хугацааг дуусах хүртэл эзэмших;
- Борлуулах боломжит; ба
- Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн, үүнд;
  - Арилжаалах зорилгоор эзэмшиж буй; эсвэл
  - Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр бүртгэгдэх.

###### Санхүүгийн өр төлбөр

Банк нь санхүүгийн баталгаа болон зээлийн үүрэг амлалтаас бусад санхүүгийн өр төлбөрийг хорогдуулсан өртгөөр эсвэл ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмждэг.

##### iii. Дараа үеийн хэмжилт

Арилжаалах зорилгоор эзэмшиж буй бүх санхүүгийн хөрөнгө, өр төлбөр, ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр бүртгэгдсэн деривативууд, ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүд болон арилжаалах боломжтой хөрөнгүүдийг анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа үед бодит үнэ цэнээр нь хэмждэг. Харин идэвхтэй зах зээл дээр зарлагдсан үнэ ханшгүй ба бодит үнэ цэнийг нь найдвартай хэмжих боломжгүй санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдийг ажил гүйлгээний өртгийг оролцуулаад өртгөөр нь хэмжих ба үнэ цэнийн бууралтын гарзыг хасдаг. Арилжааны хэрэгслүүд болон арилжаалах боломжтой хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүсэх олз, гарзыг ашиг, алдагдлаар болон шууд эзэмшигчийн өмчийн хэсэгт тус тус хүлээн зөвшөөрдөг.

Арилжааны бус санхүүгийн өр төлбөрүүд, зээл болон авлагууд, гэрээний хугацаа дуусах хүртэл эзэмших хөрөнгүүдийг хорогдуулсан өртгөөс үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр хэмждэг. Хорогдуулсан өртгийг үр ашигт хүүгийн аргаар тооцоолдог.

**3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)**

**(б) Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөр (үргэлжлэл)**

**Санхүүгийн өр төлбөр (үргэлжлэл)**

Урамшуулал ба хөнгөлөлтийг (анхны ажил гүйлгээний өртгийг хамруулаад) тухайн хэрэгслийн дансны үнэд оруулах ба үр ашигт хүүгийн хувь хэмжээнд үндэслэн хорогдуулдаг.

**iv. Үл хүлээн зөвшөөрөлт**

**Санхүүгийн хөрөнгө**

Банк нь тухайн санхүүгийн хөрөнгөөс орж ирэх мөнгөн гүйлгээг авах гэрээний эрхийн хугацаа дууссан, эсвэл тухайн хөрөнгөөс орж ирэх мөнгөн гүйлгээг эзэмших гэрээний эрхээ бусдад санхүүгийн хөрөнгийн бараг бүх өгөөж болон эрсдлийн хамтаар шилжүүлсэн, эсвэл санхүүгийн хөрөнгийн бараг бүх эрсдэл болон өгөөжийг шилжүүлээгүй боловч хадгалж үлдээгүй ба хөрөнгөд хяналт тавих эрхийг хадгалж үлдээгүй бол санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхөд хөрөнгийн дансны үнэ (эсвэл хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөгдөж буй хэсгийн дансны үнэ) болон (i) шинээр хүлээн авсан хөрөнгөөс шинээр тооцоолсон өр төлбөрийг хассаны дараах хүлээн авсан төлбөр болон (ii) бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрсөн хүримтлагдсан олз, гарзын нийлбэрийн зөрүүгээр ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Санхүүгийн хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөх нөхцлийг хангасан боловч Банк өөртөө хадгалсан хэсгийг тусдаа хөрөнгө эсвэл өр төлбөрөөр бүртгэнэ.

Банк нь санхүүгийн байдлын тайланд тусгасан байсан хөрөнгийг бусдад шилжүүлсэн боловч тэдгээр хөрөнгийн эсвэл тодорхой хэсгийнх нь бүх эсвэл бараг бүх эрсдэл, өгөөжийг хадгалсан хэвээр үлдэх хэлцэл хийх тохиолдол байдаг. Ийм тохиолдолд шилжүүлсэн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхгүй. Ийм ажил гүйлгээний жишээ нь үнэт цаасны зээл, борлуулалт болон эргүүлэн худалдан авах ажил гүйлгээ юм.

Банк нь шилжүүлсэн санхүүгийн хөрөнгийн бүх эрсдэл, өгөөжийг шилжүүлээгүй болон өөртөө хадгалаагүй боловч хөрөнгөд хяналт тавих эрхийг хадгалж үлдсэн бол Банк нь уг хөрөнгийг өөрийн оролцооны хэр хэмжээгээр өөрөөр хэлбэл шилжүүлсэн хөрөнгийн үнэ цэнийн өөрчлөлтөнд хэдий хэмжээгээр өртсөн хэвээр байгаа хувь хэмжээгээр нь бүртгэлдээ хэвээр үлдээнэ.

Санхүүгийн хөрөнгийн мөнгөн гүйлгээнд хамаарах гэрээний эрхийн хүчинтэй хугацаа дууссан эсвэл уг санхүүгийн хөрөнгийн мөнгөн гүйлгээг хүлээн авах гэрээний эрхийг шилжүүлсэн бөгөөд санхүүгийн хөрөнгийн эзэмшилтэй холбоотой бүх эрсдэл, өгөөжийг бодитойгоор шилжүүлсэн бол уг санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрдөг.



**3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)**

**(б) Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөр (үргэлжлэл)**

**iv. Үл хүлээн зөвшөөрөлт (үргэлжлэл)**

**Санхүүгийн өр төлбөр**

Банк санхүүгийн өр төлбөрийг гэрээнд тодорхойлсон үүрэг хариуцлага дуусгавар болсон, цуцлагдсан эсвэл хугацаа дуусгавар болсон үед үл хүлээн зөвшөөрдөг.

**v. Цэвэр дүн**

Банк хүлээн зөвшөөрөгдсөн дүнг хооронд нь хаах хууль эрх зүйн эрхтэй байх, мөн цэвэр дүнгээр нь төлбөр хийх эсвэл нэгэн зэрэг хөрөнгийг борлуулах, өр төлбөрийг барагдуулах зорилготой үед санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хааж санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр нь тусгадаг.

Орлого ба зардлыг эсвэл Банкны арилжааны үйл ажиллагааны гэх мэт ижил төрлийн ажил гүйлгээнээс үүссэн олз, гарзыг СТОУС-ын дагуу хүлээн зөвшөөрсөн тохиолдолд цэврээр толилуулна.

**vi. Хорогдуулсан өртгөөр хэмжих**

Санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөрийн “хорогдуулсан өртөг” нь санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөрийн анх хүлээн зөвшөөрөгдсөн дүнгээс үндсэн төлбөрийг хасч анхны хүлээн зөвшөөрсөн үнэ ба хугацааны эцэст төлөгдөх дүнгийн зөрүүгээс үнэ цэнийн бүүралтыг хассан үр ашигт хүүгийн аргаар тооцсон нийлмэл хорогдуулалтыг нэмж эсвэл хасч тооцсон дүн.

**(в) Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө**

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь касс дахь бэлэн мөнгө, төв банкинд байршуулсан хязгаарлагдаагүй харилцах, бодит үнэ цэнийн өөрчлөлтөд бага өртдөг өндөр хөрвөх чадвартай санхүүгийн хөрөнгүүд ба богино хугацааны үүргүүдийг төлж барагдуулахад ашигладаг харилцах, хадгаламжаас бүрдэж байна.

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь санхүүгийн байдлын тайланд хорогдуулсан өртгөөр илэрхийлэгддэг.

**(г) Хөрөнгө оруулалтын үнэт цаас**

Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэнээс бусад хөрөнгө оруулалтын үнэт цаасыг бодит үнэ цэнэ дээр шууд хамаарах зардлыг нэмэгдүүлсэн дүнгээр анх хүлээн зөвшөөрөх ба дараа үеийн ангиллаас хамааран хугацааны эцэс хүртэл эзэмших эсвэл ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээрх үнэт цаас, эсвэл борлуулах боломжит хэмээн бүртгэнэ.

**3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)**

**(г) Хөрөнгө оруулалтын үнэт цаас (үргэлжлэл)**

**i. Хугацааны эцэс хүртэл эзэмших**

Хугацааны эцэс хүртэл эзэмших хөрөнгө оруулалт гэдэг нь Банк хугацаа нь дуусгавар хугацаа хүртэл эзэмших хандлага болон чадвартай, ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээрх үнэт цаас эсвэл борлуулах боломжтой үнэт цаасанд хамаарахгүй, тогтмол эсвэл тодорхойлж болохуйц төлбөртэй, тогтсон хугацаатай үүсмэл бус хөрөнгийг хэлнэ.

Хугацааны эцэс хүртэл эзэмших хөрөнгө оруулалтыг үр ашигт хүүгийн арга ашиглаж тооцсон хорогдуулсан өртгөөс үнэ цэнийг бууралтыг хассан дүнгээр хэмжинэ. Багаас их хэмжээний хугацааны эцэс хүртэл эзэмших хөрөнгө оруулалтыг худалдах эсвэл дахин ангилах бол нийт бүлгээр нь борлуулах боломжит гэж дахин ангилахад хүргэх бөгөөд Банк нь дараагийн хоёр жилд аливаа нэг санхүүгийн хөрөнгийг хугацааны эцэс хүртэл эзэмших бүлэгт ангилахыг хориглодог.

Гэвч дараах нөхцлүүд дэх борлуулалт ба дахин ангилалтыг үнэт цаасны дахин ангиллын нөхцөл гэж үзэхгүй:

- Борлуулалт ба дахин ангилал нь үнэт цаасны дуусгавар хугацаатай ойрхон бөгөөд хүүгийн зах зээлийн түвшинд гарах өөрчлөлт нь тухайн санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхгүй бол;
- Банк тухайн санхүүгийн хөрөнгийн үндсэн төлбөрийн ихэнхийг хүлээн авсаны дараа борлуулах ба дахин ангилсан бол;
- Банкны хяналтаас гадуур, дахин давтагдахгүй үйл явдлын улмаас үүдсэн борлуулалт ба дахин ангилалт.

**ii. Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн**

Банк нь зарим хөрөнгө оруулалтын үнэт цаасыг бодит үнэ цэнээр толилуулж, түүнд гарсан өөрчлөлтийг ашиг, алдагдалд шууд хүлээн зөвшөөрдөг.

**iii. Борлуулах боломжтой**

Борлуулах боломжтой хөрөнгө оруулалт гэдэг нь борлуулахад бэлэн, бусад төрлийн санхүүгийн хөрөнгөөр ангилагдаагүй үүсмэл бус хөрөнгө оруулалтыг хэлнэ. Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалт нь өмчийн үнэт цаас ба өрийн үнэт цааснаас бүрдэнэ. Биржээр арилжаалагддаггүй өмчийн үнэт цаасны бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжгүй үед өртгөөр нь бүртгэнэ. Бусад борлуулах боломжтой хөрөнгө оруулалтуудыг анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа бодит үнэ цэнээр хэмжинэ.

Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Банк ногдол ашиг авах эрхтэй болох үед ногдол ашгийн орлогыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Борлуулах боломжтой өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалтаас үүссэн гадаад валютын ханшийн олз ба гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Үнэ цэнийн бууралтын гарз нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөнө.

**3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)**

**(г) Хөрөнгө оруулалтын үнэт цаас (үргэлжлэл)**

**iii. Борлуулах боломжтой (үргэлжлэл)**

Үнэ цэнийн бууралтын гарзаас бусад бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрч, эздийн өмчийн хэсэгт бодит үнэ цэнийн нөөцөөр толилуулна. Үнэт цаас борлуулах үед эздийн өмчийн хэсэгт хуримтлагдсан олз, гарзыг ашиг, алдагдал руу дахин ангилна.

Хэрвээ үүсмэл бус санхүүгийн хөрөнгө нь зээл болон авлагын тодорхойлолттой нийцэж байх бөгөөд Банк уг санхүүгийн хөрөнгийг ойрын ирээдүйд эсвэл дуусгавар хугацаа хүртэл эзэмших хандлага болон чадвартай бол борлуулах боломжтой хөрөнгийн ангиллаас зээл болон авлагын ангилал руу дахин ангилах боломжтой.

**(д) Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрөх бөгөөд анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа үндсэн хөрөнгийг тухайн хөрөнгийн өртгөөс аливаа хуримтлагдсан элэгдэл болон аливаа үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр нь бүртгэдэг. Үндсэн хөрөнгийн өртөгт тухайн хөрөнгийг худалдан авах болон барьж байгуулахтай шууд холбогдон гарсан зардал, мөн удирдлагын зорилгоор үйл ажиллагаа явуулахад бэлэн болгож түүнийг байршуулах болон шаардлагатай нөхцлийг хангахтай холбоотой гарсан бусад зардлууд, мөн тухайн хөрөнгийг задлах, зайлуулах болон байрлаж байсан талбайг нь сэргээн засварлахад гарах зардлуудыг хамааруулна.

Хэрэв үндсэн хөрөнгийн тодорхой хэсгийн элэгдүүлэх хугацаа тухайн үндсэн хөрөнгөөс ялгаатай бол тэдгээрийг үндсэн хөрөнгийн тусдаа зүйл (гол бүрэлдэхүүн) гэж үзнэ.

Банк нь дараа үеийн зардлаас эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг хүртэх магадлалтай бөгөөд тухайн зардлыг үнэн зөв хэмжих боломжтой болсон үед түүнийг үндсэн хөрөнгийн дансны үнэ дээр нэмэгдүүлэх буюу эсвэл тусдаа хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Солигдсон эд ангийн дансны үнээр хөрөнгийн дансны үнийг бүүруулна. Өдөр тутмын үйлчилгээний зардлыг тухайн зардал гарсан тайлант үеийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг түүний ирээдүйд авчрах эдийн засгийн үр өгөөжөөс нь хамаарч ашиглагдах жилийнх нь туршид шулуун шугамын аргаар тооцон байгуулдаг. Үндсэн хөрөнгийн нийт өртгийн дүнд багтсан гол бүрэлдэхүүн хэсгийн ашиглагдах хугацаа ялгаатай байгаа тохиолдолд тэдгээрт тусад нь элэгдэл байгуулдаг.

Үндсэн хөрөнгийн дансны үнэ болон данснаас хассаны цэвэр орлогын зөрүүгээр үндсэн хөрөнгийн данснаас хассаны олз, гарзыг тухайн жилийн бусад үйл ажиллагааны бус орлого (зардал)-оор хүлээн зөвшөөрдөг.

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХХК  
Санхүүгийн Тайлангийн Тодруулга  
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

### 3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

#### (д) Үндсэн хөрөнгө (үргэлжлэл)

Үндсэн хөрөнгийн зүйлсийн тайлант жил болон түүнтэй зэрэгцүүлэх хугацаанд тооцсон эдийн засгийн элэгдүүлэх хугацаа дараах байдалтай байна:

	<u>Ашиглагдах хугацаа (жилээр)</u>
Тавилга, эд хогшил	10
Тээврийн хэрэгсэл	10
Компьютер, холбогдох хэрэгсэл	3

Элэгдэл тооцох арга, ашиглалтын жил болон үлдэх өртгийг санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үздэг ба шаардлагатай бол залруулдаг. Өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтөөр тайлагнадаг.

#### (е) Биет бус хөрөнгө

Худалдан авсан программ хангамжийг өртгөөс хуримтлагдсан хорогдуулга болон үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр бүртгэдэг.

Программ хангамжийн ирээдүйн эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлэх тохиолдолд холбогдон гарсан аливаа дараа үеийн зардлыг капиталжуулна. Бусад гарсан зардлуудыг гарсан тухай бүрд нь ашиг, алдагдлаар бүртгэдэг.

Программ хангамжийн хорогдуулгыг тэдгээрийг ашиглах боломжтой болсон өдрөөс нь эхлэн тооцсон ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргаар тооцдог. Тайлант жилийн программ хангамжийн тооцоолсон ашиглагдах хугацаа нь гурван жил байна.

Тодорхой хугацаанд ашиглагдах биет бус хөрөнгийн хорогдуулах хугацаа болон хорогдуулах аргыг тайлант үе бүрийн эцэст хянаж үздэг.

#### (ё) Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдээгүй санхүүгийн хөрөнгийн хувьд тэдгээрт үнэ цэнийн бууралт үүссэн гэдэг бодит нотолгоо байгаа эсэхийг тайлант хугацааны эцэст үнэлж тодорхойлдог. Хөрөнгийг анх бүртгэснээс хойш алдагдалд хүргэх үйл явдал болсон гэдгийн бодит нотолгоо байгаа бөгөөд уг үйл явдлын улмаас тухайн хөрөнгийн ирээдүйд бий болгох мөнгөн үрсгал буурахыг найдвартайгаар тооцоолж болохоор байвал уг санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан гэж үзнэ. Гэхдээ магадлалыг үл харгалзан, ирээдүйн үйл явдлын үр дүнд хүлээгдэж буй гарзыг хүлээн зөвшөөрдөггүй.

### 3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

#### (ё) Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт(үргэлжлэл)

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын бодит нотолгоог харуулах дараах үйл явдлууд байна:

- зээлдэгчийн санхүүгийн нөхцөл байдал нэлээд хэмжээгээр хүндэрсэн;
- хүүгийн болон үндсэн төлбөрийг үл төлөх, гэрээг үл биелүүлэх гэх мэтээр гэрээний заалтыг зөрчих;
- аливаа эдийн засгийн болон хууль зүйн шалтгааны улмаас зээлдэгчийн санхүүгийн нөхцөл байдал хүндэрсэн тохиолдолд зээлдүүлэгч, зээлдэгчид хөнгөлөлт эдлүүлэх;
- зээлдэгч нь дампуурал зарлах эсвэл санхүүгийн хувьд дахин зохион байгуулалт хийх магадлалтай байгаа;
- санхүүгийн хүнд нөхцөл байдлын улмаас санхүүгийн хөрөнгийн идэвхтэй зах зээл байхгүй болсон; эсвэл
- бүлэг санхүүгийн хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш тэдгээр хөрөнгүүдийн ирээдүйн тооцоологдсон мөнгөн урсгалд хэмжигдэхүйц бууралтын шинж тэмдэг ажиглагдсан боловч бүлэг санхүүгийн хөрөнгөөс тухайн хөрөнгийн бууралтыг тусад нь тодорхойлох боломжгүй байх.

Мөн өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын хувьд бодит үнэ цэнэ нь өртгөөс бага байгаа тохиолдолд үүсэх нэлээд хэмжээний бууралт нь үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо юм.

Хэрэв санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт үүссэн бодит нотолгоо байгаа бол уг үнэ цэнийн бууралтын гарз нь хүлээн зөвшөөрөгдөн хэмжигдэхүйц байх ёстой.

Банк нь хугацааны эцэс хүртэл эзэмших хөрөнгө оруулалтын үнэт цаасны үнэ цэнийн бууралтын нотолгоог тодорхой хөрөнгийн түвшинд харгалзан үздэг.

Хорогдуулсан өртгөөр нь илэрхийлэгдсэн санхүүгийн хөрөнгө (бусад банкин дахь харилцах, хадгаламж, харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа гэх мэтчилэн)-ийн хувьд Банк эхлээд дангаараа чухал ач холбогдол бүхий санхүүгийн хөрөнгө түс бүрийн хувьд үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байгаа эсэхийг тусгайлан үнэлж, түүний дараа нь дангаараа чухал ач холбогдолгүй санхүүгийн хөрөнгийг бүлгээр нь үнэлнэ. Хэрэв Банк нь нэг бүрчлэн үнэлэгдсэн санхүүгийн хөрөнгийн үнэлгээний хувьд үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байхгүй гэж үзвэл ойролцоо зээлийн эрсдлийн шинж чанар бүхий санхүүгийн хөрөнгийн бүлэгт оруулан үнэ цэнийн бууралтыг нь нэгдсэн байдлаар үнэлдэг. Үнэ цэнийн бууралтын нэг бүрчлэн үнэлгээ хийгдсэн, үнэ цэнийн бууралтын алдагдал нь хүлээн зөвшөөрөгдсөн, эсвэл үргэлжилж буй хөрөнгийг бүлгийн үнэ цэнийн бууралтын үнэлгээнд оруулахгүй.

Үнэ цэнийн бууралтын алдагдал гарсан талаар бодит нотолгоо байгаа бол алдагдлыг тухайн хөрөнгийн бүртгэлийн дүн ба ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн (бодитоор тохиолдоогүй ирээдүйд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг оруулахгүй) зөрүүгээр хэмжинэ.

**3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)**

**(ё) Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)**

Цаашид эргэн төлөгдөх ямар нэг бодит чиг хандлага байхгүй байгаа, бүх барьцаа хөрөнгийг борлуулсан эсвэл Банкинд шилжүүлсэн үед, зээлийг холбогдох зээлийн эрсдлийн сангийн хамт данснаас хасна. Хэрэв дараагийн тайлант хугацаанд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараах үйл явдлын улмаас тооцоолсон үнэ цэнийн бууралтын алдагдал өсөж эсвэл буурвал, сангийн дансыг залруулах замаар өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтыг өсгөж эсвэл бууруулна.

Үнэ цэнийн бууралтын гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөх ба хугацааны эцэс хүртэл эзэмших хөрөнгө оруулалтын үнэт цаасны нөөцөд тусгагдсан. Үнэ цэнийн бууралттай хөрөнгийн хүү нь хөнгөлөлтийн буцаалтаар дамжуулан хүлээн зөвшөөрөгдсөөр байна. Дараа үед үнэ цэнийн бууралтын гарзын хэмжээ буурах үед үнэ цэнийн бууралтын гарзын бууралтыг ашиг, алдагдлаар буцаана.

Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн бууралтыг өөрийн хөрөнгөд хүлээн зөвшөөрсөн хуримтлагдсан алдагдлыг ашиг, алдагдал руу дахин ангиллын залруулгаар ангилна. Өөрийн хөрөнгөөс ашиг, алдагдал руу дахин ангилсан хуримтлагдсан гарз нь анхны өртгөөс буцаан төлсөн үндсэн төлбөр болон хорогдуулалтыг хассан дүн болон бодит үнэ цэнээс ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийг хассан дүнгийн зөрүү байна. Үр ашигт хүүгийн аргаар тооцсоноос үүссэн үнэ цэнийн бууралтын өөрчлөлт нь хүүгийн орлогын хэсэгт тусгагдана.

Хэрэв дараа тайлант үед борлуулах боломжтой өрийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ өссөн бөгөөд уг өсөлт нь үнэ цэнийн бууралтын гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсний дараа тохиолдсон үйл явдалтай бодитойгоор холбоотой бол үнэ цэнийн бууралтын гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөгдсөн дүнгээр нь буцаадаг. Үнэ цэнийн бууралт үүссэн борлуулах боломжтой хөрөнгийн үнэ цэнэ дараа тайлант үед өсвөл бусад дэлгэрэнгүй орлогын хэсэгт хүлээн зөвшөөрдөг.

**(ж) Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт**

Хойшлогдсон татварын хөрөнгөөс бусад Банкны санхүүгийн бус хөрөнгүүдийн дансны үнэд хөрөнгийн үнэ цэнэ буурч болзошгүй болохыг илтгэх шинж тэмдэг байгаа эсэхийг тайлант үе бүрийн эцэст үнэлдэг. Хэрэв ийм шинж тэмдэг илэрвэл хөрөнгийн нөхөгдөх дүнг тооцоолдог.

Мөнгөн хөрөнгө бий болгогч нэгжийн хувьд нөхөгдөх дүн нь мөнгөн хөрөнгө бий болгогч нэгжийн борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнэ болон ашиглалтын үнэ цэнийн аль их нь байдаг. Ашиглалтын үнэ цэнийг тооцохдоо хөрөнгийн хувьд онцлог эрсдэл болон мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн одоогийн зах зээлийн үнэлгээг тусгасан татварын өмнөх хувь хэмжээг ашиглан хөрөнгийг тасралтгүй ашигласнаас болон ашиглагдахаар тооцсон хугацааны эцэст данснаас хасах үед үүсэхээр хүлээгдэж буй тооцоолсон ирээдүйн мөнгөн үрсгалын өнөөгийн үнэ цэнээр хэмждэг. Банк бие даасан хөрөнгийн нөхөгдөх дүнг тооцдог ба хэрэв хөрөнгийн бие даасан нөхөгдөх дүнг тооцоолох боломжгүй бол банк хөрөнгөтэй хамааралтай мөнгөн хөрөнгө бий болгогч нэгжийн нөхөгдөх дүнг тодорхойлдог.

**3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)**

**(ж) Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)**

Үнэ цэнийн бууралтын гарзыг хөрөнгө эсвэл мөнгөн хөрөнгө бий болгогч нэгжийн дансны үнэ нь нөхөгдөх дүнгээс хэтэрсэн үед хүлээн зөвшөөрдөг. Үнэ цэнийн бууралтын гарзыг дэлгэрэнгүй орлогын тайланд тайлагнадаг. Мөнгө бий болгогч нэгжийн түвшинд тодорхойлогдсон аливаа үнэ цэнийн бууралт нь гүүдвилийн дансны үнийг эхлээд бууруулах бөгөөд дараа нь мөнгө бий болгогч нэгж дэх бусад хөрөнгийн дансны үнийг хувь тэнцүүлэн бууруулна. Хөрөнгийн үнэ цэнийн гарз буурсан аль эсвэл гарз үүсээгүй шинж тэмдгийг хэмжихийн тулд өмнөх үеийн хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтыг тайлант жил бүр үнэлдэг.

Нөхөгдөх дүнг тодорхойлоход ашигласан тооцоололд өөрчлөлт үүссэн тохиолдолд үнэ цэнийн бууралтыг буцаана. Үнэ цэнийн бууралтын гарзыг өмнөх жилүүдэд хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралтын гарз хүлээн зөвшөөрөөгүй байсан бол элэгдэл буюу хорогдлыг хассаны дараа тодорхойлогдох байсан дансны үнээс тухайн хөрөнгийн дансны үнийг хэтрүүлэхгүй байхаар тооцож буцаана.

**(з) Хувьцаат капитал**

Энгийн хувьцаа нь эздийн өмчийн хэсэгт ангилагддаг. Энгийн хувьцаа болон хувьцааны опцион (худалдан авах эрх) гаргахад шууд холбогдон гарах өсөн нэмэгдэх зардлыг аливаа татварын нөлөөлөлгүй цэвэр дүнгээр өмчийн хэсгийг бууруулах байдлаар хүлээн зөвшөөрдөг.

**(и) Ажилчдын тэтгэвэр, тэтгэмж**

**(i) Ажилчдын богино хугацаат тэтгэмж**

Ажилчдын богино хугацаат тэтгэмж гэдэгт ажилтан Банкинд үзүүлсэн үйлчилгээнийхээ хариуд тайлант үеийн эцсээс хойш 12 сарын дотор багтаан авахаар тохиролцсон ажилтны тэтгэмжийг хэлнэ. Ажилтан нь тайлант үеийн түрш Банкинд үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд тухайн үйлчилгээний хариуд төлөгдөхөөр хүлээгдсэн ажилчдын богино хугацааны тэтгэмжийн дискаунтчилагдаагүй дүнг хүлээн зөвшөөрдөг.

**(ii) Нийгмийн болон эрүүл мэндийн даатгал**

Хуулийн дагуу Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулж байгаа банкууд нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгалыг зохих ёсоор төлөх ёстой бөгөөд уг зардлыг гарсан тухайн үед нь дэлгэрэнгүй орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

### 3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

#### (ii) Хүү

Хүүгийн орлого ба зардлыг үр ашигт хүүгийн аргаар тооцож ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Үр ашигт хүү гэдэг нь санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрийн хүлээгдэж буй хугацаан дахь (тохиромжтой бол бага хугацаа) ирээдүйд төлөгдөх буюу хүлээн авах мөнгөн урсгалыг санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрийн дансны үнэд дискаунтчилахад ашиглаж буй хүү юм. Үр ашигт хүүгийн хувийг тооцоолоход санхүүгийн хэрэгслийн гэрээний бүх нөхцлийг харгалзан үзэж мөнгөн урсгалыг тооцох боловч ирээдүйн зээлийн алдагдлыг үүнд хамааруулахгүй.

Үр ашигт хүүгийн тооцоололд гүйлгээний зардал, хураамж, төлбөр хийсэн эсвэл хүлээн авсан хугацаа зэрэг үр ашигт хүүгийн чухал хэсгүүд багтана. Гүйлгээний зардалд санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийг худалдан авах болон борлуулахтай шууд хамаарах нэмэгдэл зардал багтана.

Ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогод түсгагдсан хүүгийн орлого ба зардал нь дараах зүйлсийг багтаана:

- үр ашигт хүүгийн аргаар тооцож, хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн хүү;
- үр ашигт хүүгийн аргаар тооцсон борлуулах боломжтой хөрөнгө оруулалтын үнэт цаасны хүү;
- хүүгийн орлого, зардалд нөлөө үзүүлж байх хугацааны хүүгийн мөнгөн урсгалын өөрчлөлтийн мөнгөн урсгалын хейджид ангилсан үүсмэл хейджингийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн бодит хэмжээ;
- хүүгийн эрсдлийн бодит үнэ цэнийн хейджид ангилсан үүсмэл хейджийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн бодит хэмжээ.

Эрсдлийн удирдлагын зорилгоор эзэмшиж буй бусад үүсмэл хэрэгсэл дэх бодит үнэ цэнийн өөрчлөлт, мөн ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн бусад санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөр нь ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнийг бусад санхүүгийн хэрэгслээс олсон цэвэр орлогоор толилуулна.

#### (к) Хураамж ба шимтгэл

Санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөрийн үр ашигт хүүгийн салшгүй хэсэгт хамаарах хураамж ба шимтгэлийн орлого, зардал нь үр ашигт хүүгийн хэмжилтэнд хамаардаг.

Бусад хураамж ба шимтгэлийн орлогод дансны үйлчилгээний хураамж, хөрөнгө оруулалтын удирдлагын хураамж, борлуулалтын хураамж, байршуулалт болон хөрвүүлэлтийн хураамж зэрэг орох бөгөөд холбогдох үйлчилгээг үзүүлэх үед нь хүлээн зөвшөөрдөг. Хэрэв зээлийг дуусгавар болох хугацаанаас нь өмнө авахаар төлөвлөөгүй бол зээлийн үүрэг хариуцлагын хураамжийг тухайн зээлийн үүрэг дуусах хүртэл шулуун шугамын аргаар хүлээн зөвшөөрнө. Бусад хураамж, шимтгэл нь ажил гүйлгээ болон үйлчилгээний төлбөртэй голдуу хамааралтай ба тухайн үйлчилгээг авсан үед нь зардлаар бүртгэнэ.



**3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)**

**(л) Арилжааны цэвэр орлого**

Арилжааны цэвэр орлого нь хөрөнгө, өр төлбөрийг арилжих олз, гарзын зөрүүнээс бүрдэх ба хэрэгжсэн, хэрэгжээгүй бодит үнэ цэнийн өөрчлөлт, хүү, ногдол ашиг, гадаад валютын зөрүү зэргийг багтаана.

**(м) Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдсэн бусад санхүүгийн хэрэгслийн цэвэр орлого**

Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдсэн бусад санхүүгийн хэрэгслийн цэвэр орлого нь арилжааны бус эрсдлийг удирдах зорилгоор эзэмшиж буй үүсмэл хейджингийн харилцааг бүрдүүлэх нөхцөлгүй ба санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөр нь ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөхтэй хамааралтай. Энэ нь бүхий л хэрэгжсэн болон хэрэгжээгүй ашиг, алдагдлын дараах бодит үнэ цэнэ эсвэл гадаад валютын зөрүүний бусад орлогыг багтаана.

**(н) Түрээс**

Түрээсийг түрээсийн хөрөнгийн эрсдэл болон өгөөж нь түрээслэгчид бүрэн шилжсэн тохиолдолд санхүүгийн түрээс хэмээн ангилан бүртгэдэг. Бусад түрээсийг үйл ажиллагааны түрээсээр ангилдаг.

*Үйл ажиллагааны түрээс*

Үйл ажиллагааны түрээсийн төлбөрийг түрээсэлсэн хөрөнгийн эдийн засгийн үр ашиг ашиглагдаж буй цаг хугацааны хүчин зүйлийг илүү оновчтойгоор харуулаагүй тохиолдолд түрээсийн хугацааны турш шулуун шугамын аргаар тооцож зардлаар хүлээн зөвшөөрдөг. Үйл ажиллагааны түрээсээс үүсч буй болзошгүй зардлыг тухайн түрээсийн хугацаанд хамаарах үеийн зардлаар хүлээн зөвшөөрдөг.

**(о) Орлогын албан татвар**

Орлогын татварын зардал нь тайлант үеийн болон хойшлогдсон татварын зардлаас бүрддэг. Тайлант үеийн татвар болон хойшлогдсон татварыг өмч эсвэл бусад дэлгэрэнгүй орлогын хэсэгт шүүд хүлээн зөвшөөрдөг зүйлстэй холбоотойгоос бусад тохиолдолд дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг.

**(i) Тайлант үеийн татвар**

Тайлант үеийн татвар гэдэг нь өмнөх жилүүдийн татварын өрийн тохируулга болон тайлант үеийн эцэст хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан эсвэл мөрдөгдөж байгаа татварын хувь хэмжээг ашиглан тухайн жилийн татвар ногдох ашиг, татварын алдагдалд суурилан хүлээгдэж буй татварын өр эсвэл авлага юм. Татвар ногдох ашгийг тооцохдоо ирээдүйн тайлант үеийн татвар ногдох ашиг (татварын алдагдал)-ийг тодорхойлоход хэрэглэгдэх татвар ногдох орлого эсвэл татвараас хасагдах зардлаар тооцогдох түр зөрүү, мөн нягтлан бодох бүртгэлийн ашгийн татвар ногдохгүй орлого, татвараас хасагдахгүй зардал зэргийг харгалзан үздэггүй учраас татвар ногдох ашиг нь нягтлан бодох бүртгэлийн ашгаас ялгаатай байдаг.

**3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)**

**(a) Орлогын албан татвар (үргэлжлэл)**

**(ii) Хойшлогдсон татвар**

Хойшлогдсон татварыг хөрөнгө, өр төлбөрийн аргыг ашиглан хүлээн зөвшөөрч бүртгэдэг бөгөөд энэ арга нь санхүүгийн тайлангийн зорилгоорх хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ болон татварын зорилгоор ашиглагдах дүн хоёрын хоорондох түр зөрүүн дээр үндэслэдэг. Бүх татвар ногдох түр зөрүүнд хойшлогдсон татварын өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөг. Хойшлогдсон татварын хөрөнгийг татвар ногдох орлого олсон үед татварын орлого ногдох нь тодорхой болсон бүх хасагдах түр зөрүүнд хүлээн зөвшөөрнө.

Дараах түр зөрүүнүүдэд хойшлогдсон татварыг хүлээн зөвшөөрдөггүй: гүүдвилийн анхдагч хүлээн зөвшөөрөлт, эсвэл бизнесийн нэгдэл биш бөгөөд ажил гүйлгээ гарах үед нягтлан бодох бүртгэлийн ашиг болон татвар ногдох ашиг/татварын алдагдлын аль алинд нөлөөлөхгүй ажил гүйлгээн дэх хөрөнгө буюу өр төлбөрийн анхдагч хүлээн зөвшөөрөлт.

Хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг тайлант хугацааны эцэст дахин хянаж үздэг ба хойшлогдсон татварын хөрөнгийн бүх эсвэл зарим өгөөжийг хүртэх хангалттай хэмжээний татвар ногдох ашиг олох магадлал үгүй болох үед компани хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг бууруулдаг.

Тайлант үеийн эцсээр хүчин төгөлдөр болсон, эсвэл хүчин төгөлдөр мөрдөж байгаа татварын хувь хэмжээ (татварын хууль)-нд үндэслэн хөрөнгө нь хэрэгжих буюу өр төлбөрийг төлөх тайлант үед мөрдөгдөхөөр хүлээгдэж буй татварын хувь хэмжээгээр хойшлогдсон татварын хөрөнгө болон өр төлбөрийг хэмждэг. Тайлант үеийн эцэст банк нь хойшлогдсон татварын өр төлбөр болон хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг нөхөх буюу барагдуулах арга хэлбэрээс үүсэж байгаа татварын үр нөлөөг хойшлогдсон татварын өр төлбөр болон хойшлогдсон татварын хөрөнгийн хэмжилтэд тусгадаг.

Банк нь тайлант үеийн татварын өр төлбөрийг тайлант үеийн татварын хөрөнгөөр суутган тооцох хууль ёсны хүчин төгөлдөр эрхтэй байх, орлогын татвараар тооцоо хийдэг ижил татварын албатай харьцдаг ба тайлант үеийн татварын өр төлбөр болон хөрөнгийг цэвэр сууриар барагдуулахаар төлөвлөсөн тохиолдолд хойшлогдсон татварын өр төлбөр болон хөрөнгийг цэвэр дүнгээр тооцдог.

Хэрэв ногдол ашиг төлөлттэй холбоотойгоор нэмэлт орлогын албан татварын зардал үүссэн бол уг орлогын албан татварын зардлыг ногдол ашгийн төлөлттэй холбоотой өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх үед орлогын албан татварын зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

### 3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

#### **(ө) Холбоотой талууд**

Энэхүү санхүүгийн тайлантай холбоотойгоор Банкны хувьд холбоотой талуудад дараах холбоо, харилцаа бүхий талууд багтана:

- i. Банкныг шууд эсвэл нэг буюу түүнээс дээш зүүчлагчаар дамжуулан шууд бусаар хянадаг, санхүүгийн болон үйл ажиллагааны бодлогын чанартай шийдвэрийг гаргахад Банканд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх чадвартай, эсвэл Банкныг хамтран хянадаг этгээд;
- ii. Банктай нэгдсэн нэг хяналтанд байдаг этгээд;
- iii. Банкны эсвэл Банкны толгой компанийн гол удирдах ажилтан, эсвэл уг ажилтны гэр бүлийн ойр дотны гишүүн, эсвэл уг ажилтны хяналтанд байдаг, хамтарсан хяналтанд эсвэл мэдэгдэхүйц нөлөөнд байдаг аж ахуйн нэгж;
- iv. (i)-д дурдсан этгээдийн гэр бүлийн ойр дотны гишүүн, эсвэл уг гишүүний хяналтанд байдаг, хамтарсан хяналтад байдаг эсвэл мэдэгдэхүйц нөлөөнд байдаг аж ахуйн нэгж;
- v. Банкны эсвэл банктай холбоотой аж ахуйн нэгжийн аль нэгнийх нь ажилчдын тэтгэвэр тэтгэмжид зориулсан ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн төлөвлөгөөг хэрэгжүүлэгч этгээд.

Хувь хүний гэр бүлийн ойр дотны гишүүд гэдэг нь Банктай ажил хэргийн харилцаанд орох явцад хувь хүнд нөлөөлөх эсвэл түүний нөлөөнд автаж магадгүй гэр бүлийн гишүүдийг хэлнэ.

#### **(р) Банк мөрдөж эхлээгүй байгаа, шинээр гарсан болон өөрчлөгдсөн СТОУС-ууд**

2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш хүчин төгөлдөр үйлчилж эхлэх хэд хэдэн шинэ стандарт, нэмэлт өөрчлөлт болон тайлбарууд нь эдгээр санхүүгийн тайланг бэлтгэхэд мөрдөгдөөгүй болно. Банкны үйл ажиллагаатай холбогдох стандарт, түүний өөрчлөлтийг доор тусгасан ба эдгээрийг Банк эрт хэрэгжүүлэх төлөвлөгөөгүй байна.

#### **СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр**

2014 оны 7 дугаар сард хэвлэгдсэн СТОУС 9 нь одоо мөрдөгдөж байгаа НББОУС 39 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба Хэмжилт-ийг орлох болсон. СТОУС 9 нь санхүүгийн хэрэглүүрийн ангилал, хэмжилтийн талаарх шинэчилсэн удирдамжийг агуулсан ба үүнд санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг тооцоход хүлээгдэж буй зээлийн алдагдлын загварыг ашиглах, мөн хейджингийн нягтлан бодох бүртгэлийн ерөнхий шинэ шаардлагууд багтсан. Мөн санхүүгийн хөрөнгийг хүлээн зөвшөөрөх болон үл хүлээн зөвшөөрөх НББОУС 39-ийн удирдамжийг уг стандартад оруулсан.

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХХК  
Санхүүгийн Тайлангийн Тодруулга  
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

### 3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

#### **(p) Банк мөрдөж эхлээгүй байгаа, шинээр гарсан болон өөрчлөгдсөн СТОУС-ууд (үргэлжлэл)**

##### ***СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр (үргэлжлэл)***

СТОУС 9 нь 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх ба заасан хугацаанаас эрт хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн. Банк 2017 оны сүүлийн хагас жилээс идэвхтэй ажиллаж эхэлсэн бөгөөд цөөн тооны зээлийг гол төлөв тайлант жилийн эцэст олгосон учир СТОУС 9-ийг хэрэгжүүлэх нөлөөлөл нь 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөр Банкны цэвэр хөрөнгөнд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхгүй гэж үзсэн.

2017 онд Монголбанкнаас арилжааны банкуудыг СТОУС 9-ийг хэрэгжүүлэхийг 2020 он хүртэл хойшлуулах шийдвэр гаргасан. Банк СТОУС 9-ийг Монголбанкнаас ирэх жилүүдэд хэрэгжүүлэхийг хойшлуулсанаас санхүүгийн тайланд үүсэх боломжит нөлөөлөл, нягтлан бодох бүртгэлийн тайлагналын зарчим, СТОУС-ын нийцэл зэргийг үнэлж байна. Үүнээс үүдэлтэйгээр СТОУС 9-ийг хэрэгжүүлсэнээс үүсэх нөлөөллийг бүрэн хэмжээнд үнэлээгүй байна.

##### ***СТОУС 15 Харилцагчтай байгуулсан гэрээний орлого***

СТОУС 15 нь хэзээ, ямар дүнгээр орлого хүлээн зөвшөөрөх талаар дэлгэрэнгүй суурийг бий болгосон. Энэ стандарт нь НББОУС 18 *Орлого*, НББОУС 11 *Барилгын Гэрээ* болон НББОУСХТ 13 *Хэрэглэгчийн Урамшууллын Хөтөлбөр* зэрэг одоо мөрдөгдөж буй стандартуудыг орлох юм.

Шинэ стандартын үндсэн зарчим нь Банк бараа эсвэл үйлчилгээ үзүүлсэний үр дүнд авахаар хүлээгдэж буй дүн нь харилцагчдад бараа эсвэл үйлчилгээ үзүүлсэний хариуд авсан дүнтэй нийцсэн дүнгээр орлого хүлээн зөвшөөрөх явдал юм. Шинэ стандарт нь орлогын тодруулгыг сайжруулах, өмнө нь дэлгэрэнгүй байдлаар хандаагүй ажил гүйлгээний удирдамжаар хангах, олон элементээс бүрдсэн гэрээний зааврыг сайжруулах зэргийг агуулсан.

СТОУС 15 нь 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх ба заасан хугацаанаас эрт хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн. Банк СТОУС 15-ыг хэрэгжүүлснээр санхүүгийн тайланд үзүүлэх болзошгүй нөлөөллийг үнэлсэн. Уг үнэлгээгээр СТОУС 15 нь Банкны одоогийн үйл ажиллагааны хүрээнд олж байгаа хүү, хураамж болон шимтгэлийн орлогын хүлээн зөвшөөрөлт эсвэл хэмжилтийн хувьд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхгүй гэж үзсэн.

##### ***СТОУС 16 Түрээс***

СТОУС 16 нь түрээслэгчийн хувьд түрээсийг балансад бүртгэх бүртгэлийн нэг загварыг танилцуулсан. Түрээслэгч нь түрээсийн хөрөнгийг ашиглах эрхийг эзэмшиж байгаагийн хувьд тухайн хөрөнгийн-ашиглах-эрхийг хүлээн зөвшөөрөх ба түрээсийн төлбөр төлөх үүргийн дагуу түрээсийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХХК  
Санхүүгийн Тайлангийн Тодруулга  
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

**3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)**

***(р) Банк мөрдөж эхлээгүй байгаа, шинээр гарсан болон өөрчлөгдсөн СТОУС-ууд (үргэлжлэл)***

***СТОУС 16 Түрээс (үргэлжлэл)***

Богино хугацаат болон бага дүнтэй зүйлсийн түрээсийн хувьд чөлөөлөх нөхцлүүд мөн тусгагдсан. Түрээслүүлэгчийн бүртгэл нь одоо мөрдөгдөж байгаа стандартаас өөрчлөгдөөгүй ба түрээслүүлэгч түрээсийг шинж чанараас нь хамааруулан санхүүгийн болон үйл ажиллагааны түрээсийн аль нэгээр нь бүртгэнэ.

Уг стандарт нь НББОУС 17 Түрээс, НББОУСХТ 4 Хэлцэлд түрээсийн шинж чанар агуулагдсан эсэхийг тодорхойлох, СТХ 15 Үйл ажиллагааны түрээс - Урамшуулал болон СТХ 27 Түрээсийн хууль эрх зүйтэй холбоотой гүйлгээний агуулгыг дүгнэх зэрэг стандартуудыг орлоно.

Уг стандарт нь 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр эсвэл түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлнэ. СТОУС 16-ыг мөрдөж эхлэх үед, эсвэл анх мөрдөж эхлэхээс өмнө СТОУС 15 Харилцагчтай Байгуулсан Гэрээний Орлогын стандартыг мөрдөж байгаа аж ахуйн нэгжүүдэд заасан хугацаанаас өмнө хэрэглэхийг зөвшөөрсөн. Банк СТОУС 16-ыг хэрэгжүүлснээр санхүүгийн тайланд үзүүлэх болзошгүй нөлөөллийг үнэлж байна.

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХХК  
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга  
 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

**4. Хүү болон түүнтэй адилтгах орлого**

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<b>2017</b>	<b>2016</b>
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	2,569,261	345,725
Монголбанкны үнэт цаасны үнэт цаас	845,571	-
Бусад банкин дахь харилцах, хадгаламж	90,008	-
	<b>3,504,840</b>	<b>345,725</b>

**5. Хүү болон түүнтэй адилтгах зардал**

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<b>2017</b>	<b>2016</b>
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	761,018	-
Харилцагчдын харилцах, хадгаламж	1,994	1,859
Репо хэлцэл	62,370	-
	<b>825,382</b>	<b>1,859</b>

**6. Хураамж ба шимтгэлийн цэвэр орлого (зардал)**

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<b>2017</b>	<b>2016</b>
<b>Хураамж ба шимтгэлийн орлого</b>		
Гүйлгээний хураамж	297	-
Дансны үйлчилгээний шимтгэл, хураамж	57,604	85
Бусад үйлчилгээ	36,802	-
	<b>94,703</b>	<b>85</b>
<b>Хураамж ба шимтгэлийн зардал</b>		
Картын үйлчилгээний шимтгэл, хураамж	(5,611)	-
Дотоодын банкны үйлчилгээний хураамж	(60,774)	(516)
Бусад хураамж	(65,479)	(23,802)
	<b>(131,864)</b>	<b>(24,318)</b>
	<b>(37,161)</b>	<b>(24,233)</b>

**7. Арилжааны цэвэр орлого**

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<b>2017</b>	<b>2016</b>
Гадаад валютын арилжааны орлого	295,272	-
Гадаад валютын арилжааны зардал	(398,156)	(174)
	<b>(102,884)</b>	<b>(174)</b>

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХХК  
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга  
 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

**8. Үйл ажиллагааны бусад цэвэр орлого**

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<b>2017</b>	<b>2016</b>
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	5,877	(10,699)
Өмчлөх бусад хөрөнгө борлуусны олз	531,459	-
Данснаас хассан найдваргүй зээлийн буцаан төлөлт	294,801	267,308
Бусад	60,075	35,661
	<b>892,212</b>	<b>292,270</b>

**9. Үйл ажиллагааны зардал**

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<b>2017</b>	<b>2016</b>
Боловсон хүчний зардлууд*	933,011	621,894
Түрээсийн зардал	238,322	-
Биет бус хөрөнгийн хорогдуулга (Тод 18)	126,238	267
Үндсэн хөрөнгийн элэгдэл (Тод 17)	91,749	60,953
Засварын зардал	90,525	5,858
Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	75,858	24,313
Харуул хамгаалалтын зардал	53,671	12,800
Хэрэглээний зардал	32,522	30,657
Бичиг хэрэг	21,621	7,976
Мэдээлэл технологи, шуудан холбооны зардал	16,536	11,028
Зар сурталчилгаа, маркетингийн зардал	15,828	2,310
Хөдөлмөр хамгаалал	11,510	529
Даатгалын зардал	9,338	396
Тээврийн зардал	6,892	2,228
Бусад зардлууд	73,721	18,871
	<b>1,797,342</b>	<b>800,080</b>

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<b>2017</b>	<b>2016</b>
<b>Боловсон хүчний зардал*:</b>		
Цалин	670,468	351,645
НДШ-ийн зардал	73,740	31,802
Ажилчдын сургалтын зардал	9,882	-
Томилолтын зардал	136,311	1,020
Бусад ажилчидтай холбоотой зардлууд	42,610	237,427
	<b>933,011</b>	<b>621,894</b>

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХХК  
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга  
 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

**10. Үйл ажиллагааны бус зардал**

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>2017</u>	<u>2016</u>
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	5,955	77,742
Үндсэн хөрөнгийн худалдсаны гарз	235,769	-
Хоол, баяр ёслолын зардал	41,150	917
Торгууль	66,594	231
Бусад	83,111	9,140
	<u><b>432,579</b></u>	<u><b>88,030</b></u>

**11. Болзошгүй алдагдлын сангийн нөхөлт / (зардал)**

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>2017</u>	<u>2016</u>
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа (Тод 16)	(325,677)	(104,828)
Зээлийн эрсдлийн сангийн буцаалт (Тод 16)	1,301,954	4,429
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө	-	(49,740)
Бусад авлага	-	(193)
Найдваргүй авлагын нөөцийн буцаалт	17,136	-
	<u><b>993,413</b></u>	<u><b>(150,332)</b></u>

**12. Орлогын албан татварын зардал**

(1) Орлогын албан татварын зардал дараах байдалтай байна:

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>2017</u>	<u>2016</u>
<b>Орлогын албан татвар</b>		
Тайлант жилийн татварын зардал	245,144	-
	<u><b>245,144</b></u>	<u>-</u>

(2) Орлогын татварын зардал ба хуулиар тогтоосон татварын хувь хэмжээг ашиглаж тооцоолсон орлогын татварын үялдаа дараах байдалтай байна:

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>2017</u>	<u>2016</u>
Татварын өмнөх ашиг / (алдагдал)	2,195,117	(426,713)
10%-ийн орлогын албан татвар (2016: 10%)	219,512	(42,671)
Татвараас хасагдахгүй зардлын нөлөөлөл	135,044	182,921
Татвар ногдохгүй орлогын нөлөөлөл	(82,428)	(140,250)
Өмнө нь хүлээн зөвшөөрөөгүй байсан татварын алдагдал	(48,183)	-
Тусгай хувь хэмжээгээр татвар ногдуулах орлогод тооцсон татварын нөлөөлөл	21,199	-
	<u><b>245,144</b></u>	<u>-</u>



**12. Орлогын албан татварын зардал (үргэлжлэл)**

(\*) Монгол Улсын “Аж Ахуйн Нэгжийн Орлогын Албан Татварын тухай” хуулийн дагуу 3 тэрбум хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах жилийн орлого олсон бол 10 хувиар, 3 тэрбум төгрөгнөөс дээш давсан татвар ногдуулах орлогын дүнгийн 25 хувиар албан татвар ногдуулдаг.

(3) Монгол Улсын Засгийн Газар зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш бизнес болон арилжааны дэд бүтцийг шинэчилсээр байгаа. Үүнтэй холбоотойгоор бизнесийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлэхүйц хууль тогтоомж, дүрэм журмууд хурдацтай өөрчлөгдөн шинэчлэгдэж байна.

Эдгээр өөрчлөлтүүд нь зарим тохиолдолд хуулийн хангалтгүй боловсруулалт, маргаантай тайлбар болон татварын албадын ялгаатай хэрэглээ зэрэг нөхцөл байдлыг үүсгэдэг. Ялангуяа, татварыг хуулийн дагуу торгууль, алданги ногдуулах эрх бүхий олон тооны байгууллагууд хянаж шалгадаг. Банк нь татварын хууль тогтоомжийн талаарх өөрсдийн ойлголт болон тайлант жилийн эцэс дэх сахүүгийн үр дүнд үндэслэн татварын өр төлбөрийг зохистойгоор тооцоолж илэрхийлсэн гэж үзэж байгаа боловч дээрх нөхцөл нь Банкинд татварын эрсдлийг үүсгэж болзошгүй ба энэхүү эрсдлийг тоон хэмжээгээр илэрхийлэх боломжгүй юм.

**13. Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах**

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<b>2017</b>	<b>2016</b>
Бэлэн мөнгө	421,601	108,834
Монголбанк дахь харилцах (төгрөг)*	45,977,080	50,771
Монголбанк дахь харилцах (валют)*	27,708,021	3,009
Үнэт цаас (3 сар хүртэл)	17,836,610	-
	<b>91,943,312</b>	<b>162,614</b>

(\*) Монголбанкны шаардлагын дагуу Монголбанкинд харилцах данс байршуулдаг. Монголбанкинд байршуулах бэлэн мөнгөний заавал байлгах үлдэгдэл нь 14 хоногийн татан төвлөрүүлсэн хөрөнгийн дундажийн 12% (2016: 12%)-аас багагүй байдаг. 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банкны заавал байлгах шаардлагатай 14 хоногийн дундаж нөөцийн хэмжээ төгрөгөөр 2,524,852 мянган төгрөг (2016 онд 16,328 мянган төгрөг) ба гадаад валютаар 4,448,619 мянган төгрөг (2016 онд 8,190 мянган төгрөг) байсан.

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХХК  
Санхүүгийн Тайлангийн Тодруулга  
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

**14. Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж**

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>2017</u>	<u>2016</u>
Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	431,350	69,352
	<u><b>431,350</b></u>	<u><b>69,352</b></u>

Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж нь дотоодын болон гадаадын банк, санхүүгийн байгууллага дахь төгрөгөөр болон гадаад валютаарх харилцах хадгаламжууд болно.

**15. Санхүүгийн хөрөнгө оруулалт- борлуулах боломжтой**

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>2017</u>	<u>2016</u>
Монголбанкны үнэт цаас	36,940,917	-
Өмчийн хөрөнгө оруулалт, өртгөөр	9,140	-
	<u><b>36,950,057</b></u>	<u>-</u>

Монголбанкны үнэт цаас нь хөнгөлөлттэй үнээр худалдаж авсан богино хугацаат хөрөнгө оруулалт юм. Дансны үнэ нь зах зээлийн үнэ цэнэтэйгээ ойролцоо байдаг.

Өмчөөрх хөрөнгө оруулалт нь хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй компанид оруулсан хөрөнгө оруулалтыг илэрхийлнэ. Үүнд: Монголын Банкны Холбоо, Зээлийн Мэдээллийн Төв, СИ ЖИ ЭФ ХХК Зээлийн Батлан Даалтын Сан зэрэг байгууллага дахь хөрөнгө оруулалт хамаарна. Өмчөөрх хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийг бодитойгоор хэмжих боломжгүй учир тэдгээрийг өртгөөр нь бүртгэдэг. Үнэлгээний техникүүдийг ашиглан хийсэн бодит үнэ цэнийн тооцооллууд хоорондоо томоохон хэмжээгээр зөрөх боломжтой. Эдгээр хөрөнгө оруулалтын хувьд идэвхтэй зах зээл байхгүй байна.

**16. Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа**

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>2017</u>	<u>2016</u>
Хөрөнгө оруулалтын зээл	36,769,612	6,251,366
Эргэлтийн хөрөнгийн зээл	33,255,744	2,943,460
Орон сууцны зээл	370,963	107,422
Бусад хэрэглээний зээл	102,536	-
	<u><b>70,498,855</b></u>	<u><b>9,302,248</b></u>
Хуримтлагдсан хүүгийн авлага	337,410	-
<b>Нийт харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа</b>	<u><b>70,836,265</b></u>	<u><b>9,302,248</b></u>
Хасах нь: харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаанд байгуулсан сан	(352,494)	(1,977,523)
<b>Цэвэр зээл ба урьдчилгаа</b>	<u><b>70,483,771</b></u>	<u><b>7,324,725</b></u>

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХХК  
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга  
 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

**16. Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа (үргэлжлэл)**

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын сангийн тохируулгыг зээлийн анги тус бүрээр нь салган үзүүлбэл:

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<b>Хөрөнгө оруулалтын зээл</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн зээл</b>	<b>Орон сууцны зээл</b>	<b>Бусад</b>	<b>Нийт</b>
<b>2017 оны 12-р сарын 31-нээр</b>					
2017 оны 01-р сарын 01-нээр	461,366	1,515,620	537	-	1,977,523
Тайлант жилд байгуулсан (Тод 11)	155,555	151,110	18,499	513	325,677
Зээлийн болзошгүй алдагдлын сангийн буцаалт (Тод 11)	(171,293)	(1,114,542)	(16,119)	-	(1,301,954)
Данснаас хасагдсан	(254,022)	(384,393)	-	-	(638,415)
Гадаад валютын хөдөлгөөний нөлөөлөл	(10,337)	-	-	-	(10,337)
<b>2017 оны 12-р сарын 31-нээр</b>	<b>181,269</b>	<b>167,795</b>	<b>2,917</b>	<b>513</b>	<b>352,494</b>

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<b>Хөрөнгө оруулалтын зээл</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн зээл</b>	<b>Орон сууцны зээл</b>	<b>Бусад</b>	<b>Нийт</b>
<b>2016 оны 12-р сарын 31-нээр</b>					
2016 оны 01-р сарын 01-нээр	116,450	1,709,286	-	1,555	1,827,291
Тайлант жилд байгуулсан (Тод 11)	296,832	(192,542)	537	-	104,827
Зээлийн болзошгүй алдагдлын сангийн буцаалт (Тод 11)	(1,750)	(1,124)	-	(1,555)	(4,429)
Гадаад валютын хөдөлгөөний нөлөөлөл	49,834	-	-	-	49,834
<b>2016 оны 12-р сарын 31-нээр</b>	<b>461,366</b>	<b>1,515,620</b>	<b>537</b>	<b>-</b>	<b>1,977,523</b>

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХХК  
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга  
 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

**17. Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн дараах байдалтай байна:

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>Барилга</u>	<u>Тавилга, эд хогшил</u>	<u>Компьютер, дагалдах хэрэгсэл</u>	<u>Тээврийн хэрэгсэл</u>	<u>Нийт</u>
<b>2017 оны 12-р сарын 31- нээр</b>					
<b>Өртөг:</b>					
2017 оны 01-р сарын 01- нээр	804,663	244,687	167,796	9,555	1,226,701
Нэмэгдсэн	236,400	361,545	137,005	1,186,868	1,921,818
Хасагдсан	(1,041,063)	-	-	-	(1,041,063)
Данснаас хассан	-	(45,325)	(17,521)	-	(62,846)
Залруулга	-	(2,268)	2,323	-	55
2017 оны 12-р сарын 31- нээр	-	558,639	289,603	1,196,423	2,044,665
<b>Хуримтлагдсан элэгдэл:</b>					
2017 оны 01-р сарын 01- нээр	208,985	212,554	64,213	-	485,752
Тайлант жилд байгуулсан (Тод 9)	5,029	21,846	47,453	17,421	91,749
Хасагдсан	(214,014)	-	-	-	(214,014)
Данснаас хассан	-	(40,176)	(16,715)	-	(56,891)
Залруулга	-	1,989	1,672	79	3,740
2017 оны 12-р сарын 31- нээр	-	196,213	96,623	17,500	310,336
<b>Дансны цэвэр дүн</b>					
<b>2017 оны 12-р сарын 31- нээр</b>	-	<b>362,426</b>	<b>192,980</b>	<b>1,178,923</b>	<b>1,734,329</b>

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХХК  
Санхүүгийн Тайлангийн Тодруулга  
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

**17. Үндсэн хөрөнгө (үргэлжлэл)**

Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн дараах байдалтай байна, үргэлжлэл:

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>Барилга</u>	<u>Тавилга, эд хогшил</u>	<u>Компьютер, дагалдах хэрэгсэл</u>	<u>Тээврийн хэрэгсэл</u>	<u>Нийт</u>
<b>2016 оны 12-р сарын 31- нээр</b>					
<b>Өртөг:</b>					
2016 оны 01-р сарын 01- нээр	804,663	350,405	66,825	-	1,221,893
Нэмэгдсэн	-	-	100,971	9,555	110,526
Данснаас хассан	-	(105,718)	-	-	(105,718)
Залруулга	-	-	-	-	-
2016 оны 12-р сарын 31- нээр	<u>804,663</u>	<u>244,687</u>	<u>167,796</u>	<u>9,555</u>	<u>1,226,701</u>
<b>Хуримтлагдсан элэгдэл</b>					
2016 оны 01-р сарын 01- нээр	188,868	209,256	55,297	-	453,421
Тайлант жилд байгуулсан (Тод 9)	20,117	31,123	9,713	-	60,953
Данснаас хассан	-	(27,976)	-	-	(27,976)
Залруулга	-	151	(797)	-	(646)
2016 оны 12-р сарын 31- нээр	<u>208,985</u>	<u>212,554</u>	<u>64,213</u>	<u>-</u>	<u>485,752</u>
<b>Дансны цэвэр дүн</b>					
<b>2016 оны 12-р сарын 31- нээр</b>	<u><b>595,678</b></u>	<u><b>32,133</b></u>	<u><b>103,583</b></u>	<u><b>9,555</b></u>	<u><b>740,949</b></u>

**18. Биет бус хөрөнгө**

Биет бус хөрөнгө хөрөнгийн хөдөлгөөн дараах байдалтай байна:

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>2017</u>	<u>2016</u>
<b>Программ хангамж</b>		
<b>Худалдан авалтын өртөг:</b>		
01-р сарын 01-нээр	27,804	21,057
Нэмэгдсэн	658,505	6,747
Данснаас хассан	(21,923)	-
Залруулга	1,687	-
12-р сарын 31-нээр	<u>666,073</u>	<u>27,804</u>

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХХК  
Санхүүгийн Тайлангийн Тодруулга  
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

**18. Биет бус хөрөнгө (үргэлжлэл)**

Биет бус хөрөнгө хөрөнгийн хөдөлгөөн дараах байдалтай байна, үргэлжлэл:

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<b>2017</b>	<b>2016</b>
<b>Хуримтлагдсан хорогдол:</b>		
01-р сарын 01-нээр	20,040	19,795
Хорогдол	126,238	267
Данснаас хассан	(21,923)	-
Залруулга	1,687	(22)
12-р сарын 31-нээр	<u>126,042</u>	<u>20,040</u>
<b>Үлдэгдэл өртөг:</b>		
01-р сарын 01-нээр	7,764	1,262
12-р сарын 31-нээр	<u><b>540,031</b></u>	<u><b>7,764</b></u>

**19. Бусад хөрөнгө**

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<b>2017</b>	<b>2016</b>
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	939,017	363,363
Хангамжийн материал	24,697	37,273
Бусад хөрөнгө	-	66
	<u><b>963,714</b></u>	<u><b>400,702</b></u>

**20. Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө**

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<b>2017</b>	<b>2016</b>
Өмчлөх бусад хөрөнгө	-	1,712,784
Хасах нь: Үнэ цэнийн бууралтын алдагдлын сан	-	(531,459)
	<u><b>-</b></u>	<u><b>1,181,325</b></u>
<i>(Мянган төгрөгөөр)</i>	<b>2017</b>	<b>2016</b>
01-р сарын 01-нээр	531,459	481,719
Тайлант жилд байгуулсан (Тод 11)	-	49,740
Өмчлөх бусад хөрөнгийн нөөцийн хэрэгжилт (Тод 8)	(531,459)	-
12-р сарын 31-нээр	<u><b>-</b></u>	<u><b>531,459</b></u>

Банк зарим зээлдэгчдийн зээл болон тэдгээр зээлд байгуулсан болзошгүй алдагдлын санг бүртгэлээс хассан бөгөөд барьцааны хөрөнгүүдийг өмчлөх бусад хөрөнгөөр бүртгэсэн. Өмчлөх бусад хөрөнгүүдийг өртөг эсвэл зах зээлийн үнээс борлуулалтын өртгийг хассан үнийн аль багаар хэмжсэн. 2017 онд өмчлөх бусад хөрөнгүүдийг борлуулсан.

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХХК  
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга  
 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

**21. Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж**

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>2017</u>	<u>2016</u>
Банк, санхүүгийн байгууллагын хадгаламж	101,911,583	-
Зээл ба урьдчилгаа	8,000,000	-
	<u><b>109,911,583</b></u>	<u>-</u>

Банк болон санхүүгийн байгууллагуудын хадгаламж нь дотоодын арилжааны банкуудын байршуулсан гадаад болон дотоодын валютаар илэрхийлэгдсэн хадгаламж юм.

Зээл ба урьдчилгаа нь 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдөр авсан 5 хоногийн дуусгавар хугацаатай богино хугацаат зээл байна.

**22. Репозит**

<u>Гэрээлэгч тал</u>	<u>Борлуулсан өдөр</u>	<u>Дуусгавар хугацаа</u>	<u>Хүүгийн хувь</u>	<u>2017 Мянган төгрөг</u>
Худалдаа Хөгжлийн Банк	2017.12.28	2018.01.02	11.0%	11,981,945
Хаан Банк	2017.12.28	2018.01.02	12.0%	24,958,972
				<u><b>36,940,917</b></u>

Банк нь Монголбанкны үнэт цаасыг ирээдүйд эргэн худалдан авах нөхцөлтэй борлуулсан. Эргүүлэн худалдан авах гэрээний үргэлжлэх хугацаа нь 5 хоног. Үнэт цаасны бодит үнэ цэнэ нь дансны үнэтэйгээ ойролцоо байна.

**23. Харилцагчдын харилцах, хадгаламж**

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>2017</u>	<u>2016</u>
Хувийн сектор		
Харилцах данс	196,406	122,869
Иргэд		
Харилцах данс	28,841	45,105
Хугацаагүй хадгаламж	29,096	40,280
Санхүүгийн байгууллага		
Харилцах данс	-	720
	<u><b>254,343</b></u>	<u><b>208,974</b></u>

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХХК  
Санхүүгийн Тайлангийн Тодруулга  
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

**24. Бусад өр төлбөр**

(Мянган төгрөгөөр)	<u>2017</u>	<u>2016</u>
Хадгаламжийн Даатгалын Корпорацид өгөх өглөг	10,000,000	-
Хуримтлагдсан хүүгийн өглөг	134,263	-
Бусад татварын өглөг	108	1,244
Клирингийн саатал	5,427	20
Бусад өглөг	148,080	192,140
	<u><b>10,287,878</b></u>	<u><b>193,404</b></u>

Банк нь Хадгаламжийн Даатгалын Корпорацийн нэрийн өмнөөс 10 тэрбум төгрөгөөр Монголбанкны үнэт цаасыг худалдан авах 1 жилийн хугацаатай хөрөнгө оруулалтын зуучлалын гэрээг 2017 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр Хадгаламжийн Даатгалын Корпорацитай байгуулсан. Гэрээний дагуу Банк нь худалдаж авсан Монголбанкны үнэт цаасны төлбөрийн тодорхой хувь хэмжээг шимтгэл болгож авахаар тохиролцсон.

**25. Хувьцаат капитал**

	<u>Хувьцааны тоо</u>		<u>2017</u>	<u>2016</u>
	<u>2017</u>	<u>2016</u>	<u>Мянган төгрөг</u>	<u>Мянган төгрөг</u>
01-р сарын 01-ний өдрөөр	16,000,000	16,000,000	16,000,000	16,000,000
Тайланд жилд гаргасан	34,000,000	-	34,000,000	-
12-р сарын 31-ний өдрөөр	<u><b>50,000,000</b></u>	<u><b>16,000,000</b></u>	<u><b>50,000,000</b></u>	<u><b>16,000,000</b></u>

Зөвшөөрөгдсөн 72,000,000 хувьцаанаас 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 50,000,000 хувьцаа гаргасан. Банкны эцсийн хяналтын эрх бүхий этгээд нь хувь хүн болно.

Монголбанкнаас 2017 оны 8 дугаар сарын 9 болон 2017 оны 9 дүгээр сарын 21-ний өдрүүдэд олгосон зөвшөөрлийн дагуу Банк дүрмийн сангаа 14,000,000 мянган төгрөг болон 20,000,000 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн. 2016 болон 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрүүдээр гаргасан бүх хувьцаанууд бүрэн төлөгдсөн бөгөөд нэгжийн 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй байсан.

2017 онд Банк 22,000,000 мянган төгрөгөөр дүрмийн сангаа нэмэгдүүлэхээр Монголбанкинд хүсэлт гаргасан ба 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Монголбанкнаас зөвшөөрөл олгосон байна. Банкны зүгээс хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө оруулалтыг 2018 оны эхний улиралд хийгдэнэ гэсэн хүлээлттэй байна.



ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХХК  
Санхүүгийн Тайлангийн Тодруулга  
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

**26. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө**

<i>(Мянган төгрөгөөр)</i>	Тодруулга	<u>2017</u>	<u>2016</u>
Бэлэн мөнгө ба Монголбанкн дахь харилцах	13	74,106,702	162,614
Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	14	431,350	69,352
Монголбанкны үнэт цаас	13	17,836,610	-
		<u>92,374,662</u>	<u>231,966</u>
Хасах нь: Монголбанкнд заавал байлгах нөөц	13	(6,973,471)	(24,518)
<b>Мөнгөн гүйлгээний тайлангийн нийт мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө</b>		<u><b>85,401,191</b></u>	<u><b>207,448</b></u>

**27. Санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнэ**

**Бодит үнэ цэнийн тодорхойлолт ба бодит үнэ цэнийн түвшин**

Дараах хүснэгтэд бодит үнэ цэнээрээ бүртгэгдсэн санхүүгийн хэрэглүүдийг бодит үнэ цэнийн түвшнээр нь ангилан үзүүлэв.

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>Түвшин 1</u>	<u>Түвшин 2</u>	<u>Түвшин 3</u>	<u>Нийт</u>
<b>2017 оны 12-р сарын 31-нээр</b>				
<b>Санхүүгийн хөрөнгө</b>				
Санхүүгийн хөрөнгө оруулалт - борлуулах боломжит	-	36,940,917	-	36,940,917
	<u>-</u>	<u>36,940,917</u>	<u>-</u>	<u>36,940,917</u>
<b>2016 оны 12-р сарын 31-нээр</b>				
<b>Санхүүгийн хөрөнгө</b>				
Санхүүгийн хөрөнгө оруулалт - борлуулах боломжит	-	-	-	-
	<u>-</u>	<u>-</u>	<u>-</u>	<u>-</u>

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар, нийтэд арилжаалагддаггүй өмчөөрх хөрөнгө оруулалт 9,140 мянган төгрөг байсан бөгөөд дээрх хүснэгтэд ороогүй болно.

2 дугаар түвшний санхүүгийн хэрэглүүрийн зах зээлийн үнэ цэнийг зах зээл дээрээс ажиглах боломжтой хүүгийн хувь хэмжээ болон бусад ижил төстэй зах зээлийн үзүүлэлтүүдээр үнэлгээний аргаар хэмжив.

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХХК  
Санхүүгийн Тайлангийн Тодруулга  
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

**27. Санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнэ (үргэлжлэл)**

**1, 2 болон 3 дугаар түвшний хоорондох хөдөлгөөн**

Бодит үнэ цэнээрээ бүртгэгдсэн, санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн бодит үнэ цэнийн 1, 2 болон 3 дугаар түвшний хооронд ямар нэг хөдөлгөөн гараагүй.

**Гол таамаглалуудын өөрчлөлтийн бодит үнэ цэнээр хэмжигдсэн 3 дугаар түвшний санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнийн нөлөө**

*Хөрөнгийн биржид бүртгэлгүй борлуулахад бэлэн хөрөнгө оруулалт*

Бодит үнэ цэнийг найдвартай тооцоолох боломжгүй тул 3 дугаар түвшний санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тооцоолох таамаглалын боломжит өөрчлөлтийн нөлөөг өртгөөр нь бүртгэсэн.

**Бодит үнэ цэнээрээ тусгагдаагүй санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнэ**

Санхүүгийн тайланд бодит үнэ цэнээрээ хараахан бүртгэгдээгүй байгаа санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнийг тодорхойлоход ашиглах аргачлал, таамаглалыг дор дурдсан болно.

**Бодит үнэ цэнэ нь дансны үнэтэйгээ ойролцоо хөрөнгө**

Дуусгавар хугацаа нь богино (нэг хүртэл жил) болон түргэн борлогдох санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн дансны үнийг бодит үнэ цэнэтэйгээ ойролцоо гэж үзнэ. Уг таамаглалыг хугацаагүй болон хугацаатай хадгаламж, хувьсах хүүтэй санхүүгийн хэрэглүүрүүдэд мөн ашиглана.

**Тогтмол хүүтэй санхүүгийн хэрэглүүр**

Хорогдуулсан өртгөөр илэрхийлэгдсэн тогтмол хүүтэй санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн бодит үнэ цэнийг Монгол улс дахь ижил төстэй санхүүгийн хэрэглүүрүүдийн одоогийн зах зээлийн хүү болон тэдгээр санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг хүлээн зөвшөөрсөн үеийн зах зээлийн хүүтэй харьцуулан тооцно.

Санхүүгийн тайланд бодит үнэ цэнээрээ тусгагдаагүй санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдийн дансны үнэ нь бодит үнэ цэнэтэйгээ ойролцоо байдаг.

**28. Болзошгүй өр төлбөр ба үүрэг амлалт**

Харилцагчдын санхүүгийн хэрэгцээ, шаардлагыг хангахын тулд, Банк нь янз бүрийн буцалтгүй үүрэг болон болзошгүй өр төлбөр хүлээж байдаг. Хэдийгээр эдгээр үүргийг санхүүгийн байдлын тайланд тусгаагүй байж болох ч, эдгээр нь зээлийн эрсдэл, улмаар Банкны нийт эрсдэлд нөлөөлж байдаг (Тодруулга 31.2).

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХХК  
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга  
 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

**28. Болзошгүй өр төлбөр ба үүрэг амлалт (үргэлжлэл)**

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<b>2017</b>	<b>2016</b>
<b>Үүрэг амлалт</b>		
Олгогдоогүй шугаман зээл	500,000	-
	<b>500,000</b>	<b>-</b>

**Болзошгүй өр төлбөр**

Аккредитив, баталгаа (нээлттэй аккредитив хамаарна) нь тусгай үйл явдал тохиолдоход харилцагчийн өмнөөс төлбөр хийх үүргийг Банкинд ногдуулдаг. Баталгаа, нээлттэй аккредитив нь зээлийн эрсдэлтэй ижил эрсдлийг агуулдаг. 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банк аливаа гуравдагч талд баталгаа гаргах зөвшөөрлийг Монголбанкнаас аваагүй байна.

**Үүрэг амлалт**

Зээлийн хэмжээг нэмэхээр шийдвэрлэх нь Банкны зүгээс зээл олгох, зээлийн шугам нээх гэрээт үүргүүдийг хүлээснийг илэрхийлдэг. Ийм үүргүүд нь тогтсон дуусах хугацаа эсвэл цуцлах бусад төрлийн заалтуудтай байдаг. Зээл олгох үүрэг нь хэрэгжээгүй байтал тус үүргийнх нь хугацаа нь дууссан байж болох тул гэрээнд заасан дүн нь ирээдүйн мөнгөний шаардлагыг илэрхийлдэг гэсэн ойлголт биш юм.

Зээлийн хэмжээг нэмэх шийдвэрүүд нь харилцагчийн тодорхой шалгууруудыг хангах байдлаас шууд шалтгаалдаг учраас зээлийн боломжит алдагдал нь нийт хэрэгжээгүй үлдсэн зээл олгох үүргүүдийн дүнгээс бага байна. Богино хугацаат зээлийн үүргээс голдуу үрт хугацаат зээлийн үүрэг нь илүүтэйгээр зээлийн эрсдэлтэй байдаг тул Банк нь зээлийн үүргүүдийнхээ дуусах хугацааг хянаж байдаг.

**Бусад үүрэг амлалт**

Банк нь жилийн эцэст биет хөрөнгө эсвэл биет бус хөрөнгө худалдаж авах аливаа үүрэг хүлээгээгүй болно.

**Үйл ажиллагааны түрээсийн үүрэг- Түрээслэгч нь Банк байх**

Банк нь цуцлах боломжтой, үйл ажиллагааны түрээсийн гэрээний дагуу түрээслэгчээр аливаа барилгыг үйл ажиллагаа явуулах зорилгоор түрээслэдэг. Банк эдгээр гэрээнүүдийн хугацааг дуусгавар болгох тохиолдолд мэдэгдлээ 6 сарын өмнө өгөх үүрэгтэй. Түрээсийн гэрээнд аливаа худалдан авах, сайжруулах боломжуудыг тусгаагүй ба Банкинд эдгээр түрээсийн гэрээнд тал болсноор аливаа хязгаарлалтууд тавигдаагүй болно.

2016 болон 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар үл цуцлагдах нөхцөлтэй нэг жил болон түүнээс дээш хугацаатай үйл ажиллагааны түрээсийн гэрээний дагуух түрээсийн хамгийн бага төлбөрүүд нь дараах байдалтай байна.

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХХК  
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга  
 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

**28. Болзошгүй өр төлбөр ба үүрэг амлалт (үргэлжлэл)**

**Үйл ажиллагааны түрээсийн үүрэг- Түрээслэгч нь Банк байх (үргэлжлэл)**

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<b>2017</b>	<b>2016</b>
Жилээс бага хугацаатай	762,961	-
1-5 жилийн хугацаатай	3,524,376	-
	<b>4,287,337</b>	-

**Шүүхийн нэхэмжлэл**

Бизнесийн онцлог шинж чанарын улмаас Банкны салбарт шүүхээр асуудлыг шийдэх явдал түгээмэл байдаг. Нэгэнт мэргэжлийн зөвлөгөө авсан, гарч болох хохирлын хэмжээг зохистойгоор тооцоолсон бол Банк нь тухайн нэхэмжлэлийн санхүүгийн байдалд үзүүлж болох сөрөг нөлөөллөөс хамгаалан дансандаа залруулах бичилт хийдэг. Тайлант жилийн эцэст Банкинд шийдэгдээгүй шүүхийн нэхэмжлэл байхгүй байсан.

**Татварын болзошгүй өр төлбөр**

Монгол Улсын татвар, валют болон гаалийн тухай хуулиудын талаарх ойлголтууд нь өөр хоорондоо ижил төстэй байдаггүй бөгөөд нилээд өөрчлөгдөж байдаг. Эдгээр хуулиудын талаарх ойлголтыг удирдлага нь Банкны ажил гүйлгээнд хэрэгжүүлэх явцад аливаа татварын бэрхшээл үүсэх явдал гарч болно.

Монгол Улсын татварын эрх бүхий байгууллага нь өөрийн хуулийн талаарх ойлголт болон байр сууриндаа илүү хатуу хандаж болох бөгөөд өмнө нь үгүйсгэж байгаагүй ажил гүйлгээнүүд дээр татварын байгууллагаас бэрхшээл үүсгэх бололцоотой юм. Үүний үр дүнд нөлөөлөхүйц хэмжээний нэмэлт татвар, торгууль болон хүүг ногдуулж болох юм. Татварын шалгалт хийх хугацааны хувьд шалгалт хийж буй тайлант жилээс өмнөх 5 жилийн хугацаа хамрагдаж болно. Зарим тохиолдолд түүнээс урт хугацааг ч хамардаг.

Монгол Улсын шилжүүлгийн үнэ тогтоох тухай хууль тогтоомжууд нь дотоод, гадаадын шилжүүлгийн үнэ тогтоохтой холбоотой бүхий л хянах боломжтой ажил гүйлгээнүүдэд шилжүүлгийн үнийн залруулга хийх, нэмэлт татвар ногдуулах боломжийг татварын эрх бүхийн байгууллагуудад олгодог. Гүйлгээний нөхцөл нь зах зээлийн нөхцлөөс өөр тохиолдолд татварын байгууллага нь татвар ногдуулах дүнгүүдийг залруулж нэмэлт татвар, торгууль болон алданги тооцох эрхтэй. Монгол Улсын шилжүүлгийн үнэ тогтоохтой холбоотой өнөөгийн дүрэм журмын ерөнхий байдлаас шалтгаалан уг асуудлын нөлөөг найдвартайгаар тооцоолох боломжгүй. Энэ нь байгууллагын санхүүгийн байдал буюу нийт үйл ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөөтэй байх магадлалтай юм.

**28. Болзошгүй өр төлбөр ба үүрэг амлалт (үргэлжлэл)**

**Активын Чанарын Үнэлгээ (АЧҮ)**

2017 оны 5 дугаар сарын 24-ний өдөр Олон Улсын Валютын Сангийн Захирлуудын Зөвлөлөөс Монгол Улсын эдийн засгийн шинэчлэлийн хөтөлбөрийн хүрээнд Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг гурван жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр баталсан. Хөтөлбөрийн хүрээнд ойролцоогоор 5.5 тэрбум ам.долларын санхүүжилт олгогдох бөгөөд Азийн Хөгжлийн Банк, Дэлхийн Банк, Япон Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард улсуудаас дэмжлэг авах юм. Хөтөлбөрийн нэгэн тулгуур нь банкны системийг сэргээн тогтворжуулж, Монголбанкны үйл ажиллагааг бэхжүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээ юм. Хөтөлбөрийн хүрээнд, Монгол Улсын Арилжааны Банкүүдын Төлбөрийн Чадварын Үнэлгээг (АЧҮ-г хамруулаад) Монголбанк зохион байгуулсан. АЧҮ-г Европын Төв Банкны Активын Чанарын Үнэлгээний Удирдамж 2-ын дагуу гүйцэтгэсэн ба Монголбанк нь тодорхой зүйлсийг Монгол Улсын нөхцөл байдалд тааруулж тусгайлан тохируулсан. Дээрх үнэлгээний урьдчилсан үр дүнг арилжааны банкуудад 2018 оны 01 дүгээр сард танилцуулсан.

АЧҮ-ний дараагаар Монголбанк макро-эдийн засгийн нөхцөл байдлууд, таамаглалуудад тулгуурлан стресс тест хийхээр төлөвлөж байгаа ба АЧҮ-ний урьдчилсан үр дүнг дагалдан хийгдэх хяналт шалгалтыг гүйцэтгэх юм. Үүнд банк тус бүрийн сүүлийн үед гарсан санхүүгийн нөхцөл байдлын өөрчлөлтүүдийг харгалзан үзэж, үнэлгээ хийх явдал хамаарна. Стресс тест болон АЧҮ-г 2018 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно гэж төлөвлөж байгаа ба түүний дараагаар холбогдох үр дүн, банкны капиталд учирч болох нөлөөллийг арилжааны банкуудад мэдэгдэх төлөвлөгөөтэй байна.

Энэхүү санхүүгийн тайланг батлан гаргах өдрөөр, АЧҮ болон стресс тестийн эцсийн үр дүн гараагүй байсан бөгөөд Монгол Улсын санхүүгийн сектор болон Банкинд үнэлгээний үр дүн хэрхэн нөлөөлөх нь хараахан тодорхой болоогүй байсан. Энэ нь зах зээлийн, хууль эрх зүйн, зээлийн болон бусад эрсдэлд (хөрөнгийн хангалттай байдлын эрсдэл үүнд хамаарна) үлэмж хэмжээний тодорхойгүй байдлыг бий болгож байгаа бөгөөд Банк эдгээр эрсдэлд хэрхэн өртөх болон үр дүн нь хэрхэх нь зөвхөн цаг хугацааны туршид тодорхой болох юм. Банкны санхүүгийн тайланд АЧҮ болон стресс тест хэрхэн санхүүгийн хувьд нөлөөлөхийг одоогоор тодорхойлох боломжгүй байгаа бөгөөд Банкны санхүүгийн тайланд энэ асуудлаар ямар нэгэн залруулга хийгдээгүй болно.

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХХК  
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга  
 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

**29. Хөрөнгө болон өр төлбөрийн хугацааны шинжилгээ**

Дараах хүснэгтэнд Банкны хөрөнгө, өр төлбөрийн эргэн төлөгдөх, барагдах хугацаагаарх шинжилгээг харуулсан. Тодруулга 31.2 "Төлбөрийн чадварын эрсдэл"-ээс Банкны зүгээс барагдуулах бууруулж тооцоогүй гэрээт үүргүүдийг харна уу.

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<b>12 сар хүртэлх</b>	<b>12 сараас дээш</b>	<b>Нийт</b>
<b>2017 оны 12-р сарын 31-нээр</b>			
<b>Санхүүгийн хөрөнгө</b>			
Бэлэн мөнгө ба			
Монголбанкн дахь харилцах	91,943,312	-	91,943,312
Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	431,350	-	431,350
Санхүүгийн хөрөнгө оруулалт:			
- борлуулах боломжтой	36,950,057	-	36,950,057
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	13,718,248	56,765,523	70,483,771
Бусад хөрөнгө (*1)	-	-	-
	<b>143,042,967</b>	<b>56,765,523</b>	<b>199,808,490</b>
<b>Санхүүгийн өр төлбөр</b>			
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	(109,911,583)	-	(109,911,583)
Репо хэлцэл	(36,940,917)	-	(36,940,917)
Харилцагчдын харилцах, хадгаламж	(254,343)	-	(254,343)
Бусад өр төлбөр (*2)	(10,241,012)	-	(10,241,012)
	<b>(157,347,855)</b>	<b>-</b>	<b>(157,347,855)</b>
	<b>(14,304,888)</b>	<b>56,765,523</b>	<b>42,460,635</b>

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХХК  
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга  
 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

**29. Хөрөнгө болон өр төлбөрийн хугацааны шинжилгээ (үргэлжлэл)**

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<b>12 сар хүртэлх</b>	<b>12 сараас дээш</b>	<b>Нийт</b>
<b>2016 оны 12-р сарын 31-нээр</b>			
<b>Санхүүгийн хөрөнгө</b>			
Бэлэн мөнгө ба			
Монголбанкн дахь			
харилцах	162,614	-	162,614
Бусад банк, санхүүгийн			
байгууллага дахь харилцах,			
хадгаламж	69,352	-	69,352
Харилцагчдад олгосон зээл			
ба урьдчилгаа	7,324,725	-	7,324,725
Бусад хөрөнгө (*1)	66	-	66
	<u>7,556,757</u>	<u>-</u>	<u>7,556,757</u>
<b>Санхүүгийн өр төлбөр</b>			
Харилцагчдын харилцах,			
хадгаламж	(208,974)	-	(208,974)
Бусад өр төлбөр (*2)	(193,404)	-	(193,404)
	<u>(402,378)</u>	<u>-</u>	<u>(402,378)</u>
	<u><b>7,154,379</b></u>	<u><b>-</b></u>	<u><b>7,154,379</b></u>

(\*1) Урьдчилгаа болон хангамжийн материал ороогүй.

(\*2) Урьдчилж орсон орлого ороогүй.

**30. Холбоотой талуудын тодруулга**

Бизнесийн ердийн үйл ажиллагааны явцад Банкны хэд хэдэн ажил гүйлгээ холбоотой талуудтай хийгдсэн. Эдгээр ажил гүйлгээг арилжааны нөхцлөөр зах зээлийн ханшаар гүйцэтгэсэн.

Д. Энхтайван, Б. Оргилмаа болон Д. Энхтуяа нар нь 2016 оны 10 дугаар сарыг хүртэл Банкны хувьцаа эзэмшигчид байсан. Дээрх хувьцаа эзэмшигчид Тээвэр Хөгжлийн Банк ХХК-ийн өөрийн эзэмшлийн хувьцаагаа 2016 оны 10 дугаар сарын 26-ны өдөр худалдсанаар уг Банкны хувьцаа эзэмшигчид байхаа больсон.

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХХК  
Санхүүгийн Тайлангийн Тодруулга  
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

**30. Холбоотой талуудын тодруулга (үргэлжлэл)**

а) Холбоотой талуудын үлдэгдэл:

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<b>Холбоо хамаарал</b>	<b>2017</b>	<b>2016</b>
<b>Харилцах ба хадгаламж:</b>			
Харилцах	Хувьцаа эзэмшигчид	31,735	-
		<b>31,735</b>	<b>-</b>

б) Холбоотой талуудын ажил гүйлгээ:

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<b>Холбоо хамаарал</b>	<b>2017</b>	<b>2016</b>
<b>Үндсэн хөрөнгө:</b>			
Борлуулсан үндсэн хөрөнгө	Өмнөх хувьцаа эзэмшигчид	-	590,649
Худалдан авсан үндсэн хөрөнгө	Хувьцаа эзэмшигчид	(52,459)	-

в) Гол удирдах албан тушаалтнуудад олгосон олговор:

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<b>2017</b>	<b>2016</b>
<b>Ажилчдад олгосон богино хугацаат тэтгэмж:</b>		
Цалин	210,990	132,245
Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл	23,209	14,547
	<b>234,199</b>	<b>146,792</b>

**31. Эрсдлийн удирдлага**

**31.1 Оршил**

Эрсдэл нь Банкны үйл ажиллагааны салшгүй хэсэг ба эдгээр эрсдлийг байнгын илрүүлэлт, хэмжилт, хяналтын үйл явцуудаар дамжуулан удирддаг. Банк нь зээлийн эрсдэл, хөрвөх чадварын эрсдэл, хүүгийн түвшний эрсдэл, валютын ханшийн эрсдэл, үйл ажиллагааны эрсдлүүдтэй тулгарч байдаг. Эдгээр эрсдлүүд нь Банкны ашигт ажиллагаа болон хөрөнгөнд шүүд алдагдал учруулах, эсхүл Банкны бизнесийн зорилгуудын биелэлтэд саад учруулж болзошгүй байдаг.



### **31. Эрсдлийн удирдлага (үргэлжлэл)**

#### **31.1 Оршил (үргэлжлэл)**

Одоо мөрдөж буй эрсдлийн удирдлагын систем нь дараах зарчмуудыг агуулсан байна. Үүнд:

- ✓ Эрсдлүүдийг удирдаж буй этгээд нь зохицуулалтын болон хэмжилтийн системийг сайн ойлгож байна;
- ✓ Төлөөлөн Удирдах Зөвлөл ("ТУЗ")-өөс тогтоосон хязгаарт эрсдлийг удирдаж байна;
- ✓ ТУЗ-өөс баталсан бизнесийн стратегийн дагуу эрсдлийг хэмжиж байна;
- ✓ Капиталын хуваарилалт нь эрсдлийн түвшинтэйгээ уялдаж байна;
- ✓ Банкны гүйцэтгэлийн зорилтууд нь эрсдэл даах байдалтай уялдаж байна.

#### **Эрсдлийн удирдлагын бүтэц, зохион байгуулалт**

Тус Банкны Эрсдлийн Удирдлагын газар нь Зээлийн Эрсдлийн Удирдлагын хэлтэс, Үйл Ажиллагаа болон Мэдээллийн Системийн Эрсдлийн Удирдлагын хэлтэс болон Зах Зээлийн Эрсдлийн Удирдлагын хэлтэс гэсэн 3 хэлтсээс бүрдэх бөгөөд Гүйцэтгэх Захиралд шүүд тайлагнан ажилладаг. ТУЗ нь эрсдлийг бүхэлд нь удирдах бөгөөд эрсдлийн бодлого, зарчмуудыг батлах үүрэгтэй. Гэсэн хэдий ч, эрсдлийг удирдах, хянах чиг үүрэг бүхий бие даасан нэгжүүд байдаг.

#### **Эрсдлийн Удирдлагын Хороо ("ЭУХ")**

ЭУХ нь эрсдлийн удирдлагын бодлого, зохицуулалтыг боловсруулдаг. ЭУХ нь бизнесийн газар, нэгжүүдийн санхүүгийн эрсдлүүдийг урьдчилан илрүүлж, удирдах мөн хүлээх эрсдлийн зохистой хэмжээг тогтоож өгөх, санхүүгийн эрсдэл ба гүйцэтгэлийг хэмжих зохистой систем, стандартууд бий болгох, эрсдлийн тайлагнал ба удирдлагын хяналтын цогц үйл явцуудыг нэвтрүүлэх үүрэгтэй. Тус хороо нь ТУЗ-ийн дэргэд ажилладаг бөгөөд Банкны Гүйцэтгэх Захирлын зүгээс зээлийн, зах зээлийн, хөрвөх чадварын үйл ажиллагааны болон бусад төрлийн эрсдлийн удирдлагын талаар авч буй арга хэмжээ нь хангалттай эсэх, гол гол эрсдлүүдийг хянах, эрсдэлтэй холбоотой үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад гүйцэтгэх түвшний туслалцаа үзүүлэх үүрэгтэй ажиллаж байна. Тус хороо нь сард 1 удаа хуралдаж Банкны эрсдлийн тайланг авч хэлэлцэн, цаашид эрсдлийг бууруулах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлдог.

#### **Аудитын Хороо**

Тус хороо нь ТУЗ-ийн дэргэд ажилладаг бөгөөд дотоод аудитын үйл ажиллагаанд хяналт тавих, хөндлөнгийн гадаад аудитыг сонгох, хянах чиг үүрэгтэй.

Тус хороо нь улиралд 1 удаа хуралддаг ба гадаад болон дотоод аудитаас Банкны үйл ажиллагаатай холбоотой бүхий л төрлийн эрсдлийг хянаж гаргасан үнэлэлт, дүгнэлттэй танилцаж, цаашид авах арга хэмжээг хэрэгжүүлэхэд хяналт тавин ажилладаг.

### **31. Эрсдлийн удирдлага (үргэлжлэл)**

#### **31.1 Оршил (үргэлжлэл)**

##### **Дотоод Аудит**

Банкны эрсдлийн удирдлагын үйл явцад Дотоод Аудитын Газар жил бүр аудит хийх ба аудитын үед Банкны журмуудын зохистой байдал хийгээд Банк эдгээр журмуудыг хэр мөрдөж байгаад хяналт хийдэг. Дотоод Аудитын Газар нь хийсэн бүх үнэлгээнийхээ үр дүнг Банкны удирдлагатай хэлэлцэж, илрүүлсэн алдаа, дутагдал болоод өгөх зөвлөмжүүдийн талаар Аудитын Хороонд болон ТУЗ-д тайлагнадаг.

##### **Актив Пассивын Удирдлагын Хороо (“АПУХ”)**

АПУХ нь актив пассивын удирдлагын нарийн төвөгтэй удирдлагыг хэрэгжүүлэх болон активыг бэлэн мөнгөнд хөрвөх чадварын ашигт болон тогтвортой байдлыг хангахын тулд зах зээлийн болон хөрвөх чадварын эрсдлийг удирдах үүрэгтэй.

АПУХ нь зах зээлийн болон хөрвөх чадварын эрсдлийг бууруулах стратеги боловсруулж хязгаарыг тогтоон үг эрсдлүүдэд чиглэсэн бүтэц, бодлогын тодорхойлдог.

##### **Зээлийн Хороо**

ТУЗ-өөс олгосон эрхийн хүрээнд Банкны зээлийн эрсдлийг хянан зохицуулах, Эрсдлийн Удирдлагын Хэлтсийн оролцоотойгоор зээлийн эрсдлийн удирдлагын стратегийг хөгжүүлж, бодлого, зарчмуудыг хэрэгжүүлэн ажилладаг.

Зээлийн Хороо нь дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг:

- ✓ Зээлийн бодлого журам, зааврыг шинэчлэх, батлах;
- ✓ Зээлийн багцын чанар, эрсдэлтэй багцыг тогтмол хянах, эрсдлийг бууруулахаар авсан арга хэмжээний биелэлтэнд хяналт тавих,
- ✓ Зээлийг холбогдох журмын дагуу ангилан эрсдлийн санг үнэн, зөв байгуулж буй эсэхэд хяналт тавих;
- ✓ Олгосон зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлт, зээлийн ашиглалт, зарцуулалт, зээлдэгчийн үйл ажиллагаа, санхүүгийн чадвар, барьцаа хөрөнгийн байдалд тогтмол хяналт тавих;
- ✓ Бизнесийн салбар, газарзүйн бүсийн хувьд олгогдох зээлийн хэмжээ, хязгаарыг тогтоон батлах.

##### **Комплаенсийн Газар**

Банкны COMPLAENСийн Газар нь Гүйцэтгэх Захирлын шууд удирдлага дор Банкны бизнесийн үйл ажиллагааны салшгүй бөгөөд хараат бус нэгж байхаар бүтэцлэгдсэн. COMPLAENСийн газрын үндсэн зорилго нь Банкинд учирч болзошгүй COMPLAENСийн аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх үүднээс Банкны удирдлагыг мэдээллээр бүрэн хангах, үйл ажиллагаатай нягт уялдаа бүхий ил тод, ойлгомжтой журам, зааварчилгааг боловсруулах, COMPLAENСийн системтэй сургалтуудыг нийт ажилтнуудын хүрээнд тогтмол зохион байгуулах замаар COMPLAENСийн ёс зүй, соёлыг Банкинд бүрэлдүүлэх юм.

### **31. Эрсдлийн удирдлага (үргэлжлэл)**

#### **31.1 Оршил (үргэлжлэл)**

##### **Комплаенсийн Газар, үргэлжлэл**

Комплаенсийн газрын үндсэн үйл ажиллагаа нь комплаенстай холбоотой аливаа эрсдлүүд, энэ дундаа санхүүгийн гэмт хэрэгтэй холбоотой эрсдлүүдээс урьдчилан сэргийлэх арга хэмжээдийг авч, хяналт тавьж ажиллах ба эргээд тус газрын үйл ажиллагаа, бодлого журмын хэрэгжилтэд дотоод болон хөндлөнгийн аудит, хяналт шалгалтууд тогтмол хийгддэг нь Банкны комплаенсийн газрын үйл ажиллагааны бүтээмж, чанарыг сайжруулах давуу талуудтай.

##### **Эрсдлийг хэмжих болон тайлагнах систем**

Банк нь статистик загваруудын тусламжтайгаар түүхэн алдагдлаас ойролцоолон тооцсон ердийн тохиолдолд хүлээж болзошгүй алдагдал болон гэнэтийн тохиолдолд учирч болзошгүй онцгой алдагдлыг давхар хэмжиж чадах системийг ашиглан эрсдлийг хэмждэг. Эдгээр статистик загваруудыг түүхэн өгөгдлөөр тооцсон магадлалыг эдийн засгийн өнөөгийн орчинд нийцүүлэх байдлаар хэрэглэдэг. Мөн Банкинд тохиолдох магадлал тун багатай боловч тохиолдож болох хамгийн муу төлөвүүдийг гаргадаг.

Эрсдлийн удирдлага, хяналт нь гол төлөв Банкнаас тогтоосон хязгаарын биелэлтэд суурилна. Эдгээр хязгааруудад Банк өөрийн бизнесийн стратеги зорилт, тухайн зах зээлийн орчин, мөн цаашид хүлээх боломжтой эрсдлийн түвшинг тусгаж өгсөн байна. Үүнээс гадна Банк нь өөрийн эрсдэл даах чадварыг бүх үйл ажиллагаа болон эрсдлийн төрлүүдээр тодорхойлон хэмжиж, түүнд хяналт тавьж байдаг.

Эрсдлийг цаг алдалгүй олж таних, шинжлэх, хянах үүднээс бизнесийн бүх нэгжүүдээс цуглуулсан мэдээллүүдийг шинжилж үздэг. Ингэж боловсруулсан мэдээллийг ТУЗ, ЭУХ, бүх газар, хэлтсийн захирлуудад танилцуулж, тайлбарладаг.

##### **Эрсдлийг бүүруулах**

Хүүгийн түвшний эрсдэл, гадаад валютын ханшийн өөрчлөлт, зээлийн эрсдэл болон ирээдүйн үйл ажиллагаанаас үүдэж болзошгүй эрсдлийн хэмжээг мэдрэмжийн шинжилгээний аргаар тооцон, хянаж ажилладаг. Банк зээлийн эрсдлийг бүүруулах зорилгоор барьцаа хөрөнгө авдаг.

#### **31.2 Зээлийн эрсдэл**

##### **Эрсдлийн хэт төвлөрөл**

Төвлөрөл нь хэд хэдэн харилцагчид ижил төрлийн бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг эсхүл улс төр, эдийн засаг болон бусад аливаа өөрчлөлт гарахад тэдгээрийн гэрээний үүргээ гүйцэтгэхэд ижил маягаар нөлөөлөхөөр байвал үүсдэг. Төвлөрөл нь тухайн нэг эдийн засгийн салбарт нөлөөлж буй нөхцөл байдалд Банк хэрхэн гүйцэтгэлээ хангах мэдрэмжийг илтгэнэ.

**31. Эрсдлийн удирдлага (үргэлжлэл)**

**31.2 Зээлийн эрсдэл (үргэлжлэл)**

**Эрсдлийн хэт төвлөрөл (үргэлжлэл)**

Эрсдлийн хэт төвлөрлөөс зайлсхийхийн тулд Банк нь өөрийн бодлого, журамдаа олон төрлийн багцтай байх тодорхой удирдамжийг тусгасан байдаг. Банк нь зээлийн эрсдэлд өртөх төвлөрсөн эрсдлийн дээд хэмжээг зээлийн багц болон зээлдэгч тус бүрээр тогтоон хянаж удирддаг. Зээлдэгч нэг бүр дээр Монголбанк (Төв банк) дараах стандарт хязгаарлалтуудыг биелүүлэхийг шаарддаг. Үүнд:

- i. Нэг зээлдэгч, түүнд холбогдох этгээдэд олгох нийт зээлийн дүн болон зээлтэй адилтгах бусад активын дээд хэмжээг өөрийн хөрөнгийн 20%-аас хэтрүүлэхгүй байх.
- ii. Банкны хувь нийлүүлэгч, ажилтан, тэдгээрт холбогдох этгээдэд олгосон зээлийн хэмжээ болон зээлтэй адилтгах бусад активын дүн нь өөрийн хөрөнгийн 5%-аас, тэдгээрийн нийлбэр дүн нь өөрийн хөрөнгийн 20%-аас хэтрүүлэхгүй байх бодлого баримталдаг.

Банкны харилцагч, үйлчлүүлэгч, зээлдэгчид зээлийн хүү, үндсэн төлбөрийг төлөх чадваргүй болох эсхүл төлөхийг хүсэхгүй байх, зээлийн гэрээний болон бусад санхүүгийн хэрэгслүүдтэй холбоотой үүргээ биелүүлэхгүй байх эрсдэлд Банк өртдөг.

Банкны Эрсдлийн Удирдлагын Хороо ("ЭУХ") дахь Байгууллагын Банкны Газраар ("ББГ") дамжуулан Банкны зээлийн багцыг хэт төвлөрүүлэхгүй байхаар удирдан ажилладаг. ББГ нь Банкны хүлээх зээлийн эрсдлийн түвшинг нэг зээлдэгч болон нэг бүлэг зээлдэгч эсхүл нэг аж үйлдвэрийн салбарын хувьд хүлээн зөвшөөрч болох эрсдлийн хэмжээнд хязгаар тавих замаар зохицуулдаг. Ийм эрсдлүүдийг эргэж хянаж байдаг бөгөөд хязгаарыг жилд нэгээс доошгүй удаа дахин хянадаг. Нэг харилцагчид олгох зээлийн дээд хэмжээ болон зээлийн бүтээгдэхүүний багцын хязгаар зэргийг ТУЗ батлах ба ББГ-аас тодорхой хугацаа тутамд хянадаг.

Зээлийн төлбөрийг эргүүлэн төлөх чадвартай зээлдэгч болон зээлдэгчийн зээлжих чадварыг шинжлэх байдлаар, мөн шаардлагатай бол дээр дурдсан хязгааруудыг шинэчлэн өөрчлөх замаар зээлийн эрсдлийг удирдана. Зээлийн эрсдлийг барьцаа хөрөнгө, компанийн болон гуравдагч этгээдийн батлан даалтаар мөн бууруулж болно. ББГ нь зээлийн хяналт, багцын удирдлага гэсэн 2 чиглэлд голлон үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд зээлийн эрсдлийн үнэлгээний аргачлалаар зээл болон зээлдэгчид үнэлгээ өгөх, зээлийн багцад Монголбанкны Активыг ангилах, эрсдлийн сан байгуулж, зарцуулах журмын дагуу зээл төлөхөд учирч болзошгүй эрсдлийн санг байгуулж, түүнийг удирдан ажиллаж байна. Зээлдэгчийн үйл ажиллагаа, төлбөрийн чадварын байдалд хийх шинжилгээ судалгааг сайжруулж, зээлжих чадварын эрсдлийг бууруулах зорилгоор ББГ-тай хамтран иргэдийн зээлийн судалгаанд скорингийн аргачлалыг нэвтрүүлсэн.

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХХК  
Санхүүгийн Тайлангийн Тодруулга  
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

**31. Эрсдлийн удирдлага (үргэлжлэл)**

**31.2 Зээлийн эрсдэл (үргэлжлэл)**

**Барьцаа хөрөнгө болон бусад зээлийн баталгаа, батлан даалтыг тооцохгүйгээр зээлд учирч болзошгүй эрсдлийн дээд хэмжээг авч үзвэл**

Дараах хүснэгт нь тайлан тэнцлийн үзүүлэлт бүрийн хувьд зээлийн эрсдэлд өртөж болох нийт багцыг харуулсан байна. Эрсдэлд өртөж болох нийт багцыг барьцаа хөрөнгөөр эрсдлийг бууруулахаас өмнөх нийт дүнгээр илэрхийлсэн болно.

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<b>Тодруулга</b>	<b>2017</b>	<b>2016</b>
Бэлэн мөнгө ба Монголбанкн дахь харилцах (касс дахь бэлэн мөнгийг оролцуулаагүй)	13	91,521,711	53,780
Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	14	431,350	69,352
Санхүүгийн хөрөнгө оруулалт	15	36,950,057	-
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	16	70,836,265	9,302,248
<b>Балансын дотуурх нийт дүн</b>		<b>199,739,383</b>	<b>9,425,380</b>
Үүргүүд	28	500,000	-
<b>Балансын гадуурх нийт дүн</b>		<b>500,000</b>	-
<b>Зээлийн эрсдэлд өртөж болох нийт дүн</b>		<b>200,239,383</b>	<b>9,425,380</b>

Бодит үнэ цэнээр бүртгэгддэг санхүүгийн хэрэглүүрүүдийн хувьд дээрх дүнгүүд нь өнөөгийн зээлийн эрсдлийн өртөлтийг харуулсан ба энэ нь ирээдүйд үнэ цэнэ өөрчлөгдөхөөс шалтгаалж бий болж болох эрсдлийн дээд хэмжээ биш юм.

**Эрсдлийн төвлөрөл (аж үйлдвэрийн салбараар)**

Доорх хүснэгтэд Банкны харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааг (Тодруулга 16) аж үйлдвэрийн салбараар нь ангилан, нийт дүнгээр зээлийн барьцаа хөрөнгө эсвэл зээлийн чанарыг сайжруулах бусад зүйлүүдийн бодит үнийг авч үзэхээс өмнөх дүнгээр нь үзүүлэв.

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХХК  
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга  
 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

**31. Эрсдлийн удирдлага (үргэлжлэл)**

**31.2 Зээлийн эрсдэл (үргэлжлэл)**

**Эрсдлийн төвлөрөл (аж үйлдвэрийн салбараар), (үргэлжлэл)**

(Мянган төгрөгөөр)	2017		2016	
	Нийт багцын		Нийт багцын	
	хэмжээ	%	хэмжээ	%
Тээвэр ба харилцаа холбоо	2,504,448	3.5%	-	-
Үйлдвэрлэл	-	-	2,000,000	21.5%
Худалдаа	12,099,705	17.1%	-	-
Зочид буудал, ресторан	10,902,739	15.4%	2,000,000	21.5%
Хөдөө аж ахуй	-	-	1,147,842	12.3%
Орон сууц	372,632	0.5%	107,422	1.2%
Барилга	19,372,885	27.3%	2,000,000	21.5%
Уул уурхай ба хайгуул	16,866,722	23.8%	647,689	7.0%
Бусад	8,717,134	12.4%	1,399,295	15.0%
	<b>70,836,265</b>	<b>100.0%</b>	<b>9,302,248</b>	<b>100.0%</b>

**Зээлийн барьцаа хөрөнгө ба бусад сайжруулалтууд**

Шаардлагатай барьцаа хөрөнгийн дүн болон төрөл нь зээлдэгч болон харилцагчийн зээлийн эрсдлийн үнэлгээ ба олгох зээлийн төрлөөс хамаарна. Банк нь барьцаанд авах хөрөнгийн төрөл болон үнэ цэнийг тодорхойлохдоо Зээлийн Хорооноос гаргасан зааварчилгааг дагаж мөрддөг.

Банк нь барьцаа хөрөнгүүдийг биетээр нь шалгаж үздэг ба тэдгээрийн зах зээлийн үнийг тогтмол хянаж байдаг. Шаардлагатай бол гэрээнд заасны дагуу нэмэлт барьцаа хөрөнгийг авдаг. Зээлийн алдагдлаар хаах сангийн хэмжээ зохистой байгаа эсэхийг шалгах үедээ барьцаа хөрөнгийн зах зээлийн үнийг хянаж үздэг.

**Санхүүгийн хөрөнгийн бүлэг нэг бүрийн чанар**

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны чанарыг Банк дотооддоо хэрэглэдэг зээлийн үнэлгээний системийг ашиглан удирддаг.

Банкны зээлийн эрсдлийн үнэлгээний системийг дараах хүснэгтээр үзүүлэв:

Зээлийн зэрэглэл	Тодорхойлолт
1	Хэвийн
2	Хугацаа хэтэрсэн
3	Хэвийн бус
4	Эргэлзээтэй
5	Муу

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХХК  
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга  
 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

**31. Эрсдлийн удирдлага (үргэлжлэл)**

**31.2 Зээлийн эрсдэл (үргэлжлэл)**

Банк тус 5 зэрэглэлтэй эрсдлийн үнэлгээг нийт зээлийн багцыг эрсдлийн шинж чанарын дагуу бүлэглэхийн тулд ашигладаг. Тоон болон чанарын түүхэн өгөгдлүүд нь Банкны Зээлийн Эрсдлийн Удирдлагын хэлтэст хэрэглэж буй төсөөллүүдийн үндэс суурь болж өгдөг.

2017 оны 12-р сарын 31-нээр	Хугацаа хэтрэлтгүй ба үнэ цэнийн бууралтгүй Хэвийн	Хугацаа хэтэрсэн эсвэл дангаараа үнэ цэнийн бууралтад орсон				Нийт
		Хугацаа хэтэрсэн	Хэвийн бус	Эргэл-зээтэй	Муу	
<i>(Мянган төгрөгөөр)</i>						
Бэлэн мөнгө ба Монголбанкин дахь харилцах	13	91,943,312	-	-	-	91,943,312
Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	14	431,350	-	-	-	431,350
Санхүүгийн хөрөнгө оруулалт – борлуулах боломжит	15	36,950,057	-	-	-	36,950,057
<b>Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа</b>						
Хөрөнгө оруулалт	16	36,953,123	-	-	-	36,953,123
Ажлын капитал	16	33,407,512	-	-	-	33,407,512
Орон сууц	16	372,632	-	-	-	372,632
Бусад хэрэглээний зээл	16	102,998	-	-	-	102,998
		70,836,265	-	-	-	70,836,265
<b>Нийт</b>		<b>200,160,984</b>	-	-	-	<b>200,160,984</b>

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХХК  
Санхүүгийн Тайлангийн Тодруулга  
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

**31. Эрсдлийн удирдлага (үргэлжлэл)**

**31.2 Зээлийн эрсдэл (үргэлжлэл)**

2016 оны 12-р сарын 31- нээр	Хугацаа хэтрэлтгүй ба үнэ цэнийн бууралтгүй Хэвийн	Хугацаа хэтэрсэн эсвэл дангаараа үнэ цэнийн бууралтад орсон					Нийт
		Хугацаа хэтэрсэн	Хэвийн бус	Эргэл- зээтэй	Муу		
<i>(Мянган төгрөгөөр)</i>							
Бэлэн мөнгө ба Монголбанкн дахь харилцах	13	162,614	-	-	-	-	162,614
Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	14	69,352	-	-	-	-	69,352
<b>Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа</b>							
Хөрөнгө оруулалт	16	2,000,000	4,000,000	-	-	251,366	6,251,366
Ажлын капитал	16	1,399,295	37,412	-	-	1,506,753	2,943,460
Орон сууц	16	107,422	-	-	-	-	107,422
		<b>3,506,717</b>	<b>4,037,412</b>	-	-	<b>1,758,119</b>	<b>9,302,248</b>
<b>Нийт</b>		<b>3,738,683</b>	<b>4,037,412</b>	-	-	<b>1,758,119</b>	<b>9,534,214</b>

**Үнэ цэнийн бууралтын үнэлгээ**

Зээлийн үндсэн ба хүүгийн графикт төлбөр 90-ээс дээш хоногоор хугацаа хэтэрсэн, зээлдэгчийн мөнгөн урсгалд мэдэгдэхүйц хүндрэл учирсан, зээлийн үнэлгээ буурсан, зээлийн гэрээний анхны нөхцөл зөрчигдсөн эсэх зэрэг асуудлуудыг зээлийн үнэ цэнийн бууралтын шинжилгээ хийх явцад авч үздэг.

Банк нь өндөр дүнтэй зээл, урьдчилгаанд нэг бүрчлэн зээлийн эрсдлийн тохирох санг тооцдог. Зээлийн үнэ цэнийн бууралтын хэмжээг тодорхойлоход зээлдэгчийн бизнес төлөвлөгөөний тогтвортой байдал, санхүүгийн хүндрэл тохиолдсон үед гүйцэтгэлээ сайжруулах чадвар, дампуурал тохиолдсон үед хүлээн авах төлбөр болон хүлээгдэж буй ногдол ашгийн төлбөр, санхүүгийн өөр бусад дэмжлэг авах боломжууд, барьцаа хөрөнгийн бодит үнэ цэнэ, хүлээгдэж буй мөнгөн урсгалын хугацаа зэргийг зайлшгүй авч үздэг. Үнэ цэнийн бууралтаас үүсэх алдагдлын хэмжээг гэнэтийн үйл явдлуудын улмаас илүү нухацтай авч үзэх шаардлагатай байгаагаас бусад тохиолдолд тайлант өдөр бүр үнэлж үзнэ.



### 31. Эрсдлийн удирдлага (үргэлжлэл)

#### 31.3 Төлбөрийн чадварын эрсдэл

Санхүүгийн хэвийн болон тогтворгүй нөхцөл байдалд харилцагчийн өмнө хүлээсэн төлбөр тооцооны үүргээ гүйцэтгэж чадахгүй байвал Банк төлбөрийн чадварын эрсдэлд орно. Харилцагчдын гэнэтийн их хэмжээний бэлэн мөнгөний татан авалтын үед бэлэн байх ёстой эх үүсвэрийн доод хэмжээг Банк тогтоож өгдөг. Зээлээр авсан болон өөрийн эх үүсвэрийн зохистой харьцааг барьж байх бодлогыг Банк явуулдаг. Үүнээс гадна, Банк нь нийт харилцагчдын хадгаламжийн 12%-тай (2016: 12%) тэнцэх бэлэн мөнгийг Монголбанкинд заавал байршуулж байх ёстой.

#### Санхүүгийн өр төлбөрийг гэрээний үлдэж буй хугацаагаар хийсэн шинжилгээ

Доорх хүснэгтэд 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн өр төлбөрүүдийн дуусгавар хугацааг тэдгээрийн аливаа нэг хөнгөлөлтгүйгээр, гэрээний дагуу эргэн төлөх үүргүүд дээр үндэслэн харууллаа. Урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр төлөгдөх ёстой өр төлбөрийн хувьд уг мэдэгдэл тэр даруй ирсэн гэж тооцов. Гэсэн хэдий ч, Банк харилцагчдын дийлэнх нь гэрээт хугацаанаасаа өмнө зарлагын гүйлгээ хийхгүй гэсэн хүлээлттэй байгаа ба хадгаламжийн татан авалтын түүхэн өгөгдлүүд дээр үндэслэн Банкны хүлээж буй мөнгөн урсгалыг хүснэгтэд тусгаагүй болно. 2017 оны эцэст Банк өр төлбөрүүдийг түргэн хөрвөх хөрөнгөөр хангалттай хэмжээнд нөхөх боломжтой байна.

(Мянган төгрөгөөр)

		2017			
		Хугацаагүй	6 сар хүртэл	Дискаунтлаагүй нийт дүн	Дансны үнэ
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	21	71,775,933	38,251,678	110,027,611	109,911,583
Репо хэлцэл	22	-	37,000,000	37,000,000	36,940,917
Харилцагчдын харилцах, хадгаламж	23	254,343	-	254,343	254,343
Бусад өр төлбөр	24	10,287,878	-	10,287,878	10,287,878
		<b>82,318,154</b>	<b>75,251,678</b>	<b>157,569,832</b>	<b>157,394,721</b>

(Мянган төгрөгөөр)

		2016			
		Хугацаагүй	6 сар хүртэл	Дискаунтлаагүй нийт дүн	Дансны үнэ
Харилцагчдын харилцах, хадгаламж	23	208,974	-	208,974	208,974
Бусад өр төлбөр	24	193,404	-	193,404	193,404
		<b>402,378</b>	<b>-</b>	<b>402,378</b>	<b>402,378</b>

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХХК  
Санхүүгийн Тайлангийн Тодруулга  
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

### **31. Эрсдлийн удирдлага (үргэлжлэл)**

#### **31.4 Зах зээлийн эрсдэл**

Зах зээлийн эрсдэл гэдэг нь хүүгийн түвшин, гадаад валютын ханш гэх мэт зах зээлийн хувьсагчуудын өөрчлөлтийн улмаас санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнэ эсвэл ирээдүйн мөнгөн үрсгал хэлбэлзэх эрсдлийг хэлнэ.

#### **Хүүгийн түвшний эрсдэл**

Тодорхой хугацаа заагуудад хүүгийн түвшинг тохируулж өгч байх шаардлагатай позицууд хоорондоо таарамжгүй болох үед хүүгийн эрсдэл бий болдог. Банкны зээлийн болон санхүүжилтийн, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанууд нь хүүгийн эрсдлийг бий болгодог. Хүүгийн хувь хэмжээний өөрчлөлт нь Банкны хүүгийн цэвэр орлогод тэр даруй нөлөөлдөг бол урт хугацаанд Банкны өөрийн хөрөнгөнд нөлөөлдөг (Банкны хөрөнгө, өр төлбөр, тэнцлийн гадуурх зүйлсийн эдийн засгийн үнэ цэнэд нөлөөлөх учраас). Тодорхой хугацаанд байж болох хүүгийн хувь хэмжээний өөрчлөлтийн хязгаарыг Банкны удирдлага тогтоож өгдөг. Гэвч Банк нь зөвхөн тогтмол хүүтэй зээл олгодог. Банк нь цөөн хөвөгч хүүтэй зээлтэй тул хүүгийн түвшний эрсдэл нь материаллаг бус юм.

#### **Гадаад валютын эрсдэл**

Гадаад валютын эрсдэл гэдэг нь санхүүгийн хэрэглүүрийн үнэ цэнэ гадаад валютын ханшийн өөрчлөлтийн улмаас хэлбэлзэх эрсдэл юм. Банкны удирдлага гадаад валютын позицууд дээр хязгаар тогтоож өгдөг ба тэдгээрийг тогтмол хянадаг.

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХХК  
Санхүүгийн Тайлангийн Тодруулга  
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

31. Эрсдлийн удирдлага (үргэлжлэл)

31.4 Зах зээлийн эрсдэл (үргэлжлэл)

Дараах хүснэгтэд гадаад валютын эрсдэлд өртөж болох Банкны хөрөнгийн дүнг 2017 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар үзүүлэв. Хүснэгтэд санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдийн бүртгэлийн дүнг гадаад валют тус бүрээр бүлэглэн үзүүлэв.

2017 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар  
(Мянган төгрөгөөр)

	Тодруулга	Төгрөг	Ам.доллар	Евро	Бусад	Нийт
<b>Санхүүгийн хөрөнгө</b>						
	13	63,828,634	12,222,060	17,460	15,875,158	91,943,312
	14	119	84,454	532	346,245	431,350
<b>Санхүүгийн хөрөнгө оруулалт</b>						
-	15	36,950,057	-	-	-	36,950,057
	16	21,454,851	36,885,923	-	12,142,997	70,483,771
		<b>122,233,661</b>	<b>49,192,437</b>	<b>17,992</b>	<b>28,364,400</b>	<b>199,808,490</b>
<b>Санхүүгийн өр төлбөр</b>						
	21	26,005,031	55,900,593	-	28,005,959	109,911,583
	22	36,940,917	-	-	-	36,940,917
	23	189,904	56,375	7,382	682	254,343
	24	10,254,165	33,713	-	-	10,287,878
		<b>73,390,017</b>	<b>55,990,681</b>	<b>7,382</b>	<b>28,006,641</b>	<b>157,394,721</b>
		<b>48,843,644</b>	<b>(6,798,244)</b>	<b>10,610</b>	<b>357,759</b>	<b>42,413,769</b>

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХХК  
Санхүүгийн Тайлангийн Тодруулга  
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

31. Эрсдлийн удирдлага (үргэлжлэл)

31.4 Зах зээлийн эрсдэл (үргэлжлэл)

2016 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар  
(Мянган төгрөгөөр)

	Тодруулга	Төгрөг	Ам.доллар	Евро	Бусад	Нийт
<b>Санхүүгийн хөрөнгө</b>						
Бэлэн мөнгө ба Монголбанкн дэхь харилцах	13	149,455	12,650	509	-	162,614
Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	14	34,425	33,850	1,077	-	69,352
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	16	7,324,725	-	-	-	7,324,725
Бусад хөрөнгө		-	66	-	-	66
		<b>7,508,605</b>	<b>46,566</b>	<b>1,586</b>	-	<b>7,556,757</b>
<b>Санхүүгийн өр төлбөр</b>						
Харилцагчдын харилцах, хадгаламж	22	139,101	61,226	7,356	1,291	208,974
Бусад өр төлбөр	24	190,691	770	1,943	-	193,404
		<b>329,792</b>	<b>61,996</b>	<b>9,299</b>	<b>1,291</b>	<b>402,378</b>
<b>Цэвэр позиц</b>		<b>7,178,813</b>	<b>(15,430)</b>	<b>(7,713)</b>	<b>(1,291)</b>	<b>7,154,379</b>

### **31. Эрсдлийн удирдлага (үргэлжлэл)**

#### **31.4 Зах зээлийн эрсдэл (үргэлжлэл)**

##### **Урьдчилан төлөлтийн эрсдэл**

Урьдчилан төлөлтийн эрсдэл гэдэг нь Банкны үйлчлүүлэгч ба харилцагч нь хүлээж байснаас өмнө эсвэл хойно төлбөрөө хийх эсвэл төлбөр хийхийг хүссэний улмаас санхүүгийн алдагдалд орох эрсдэл юм.

Банк нь төрөл бүрийн түвшний урьдчилан төлөлтүүдийн хүүгийн цэвэр орлогод үзүүлэх нөлөөллийг урьдчилан тооцоолохдоо хялбаршуулсан аргыг авч хэрэглэдэг.

##### **Үйл ажиллагааны эрсдэл**

Үйл ажиллагааны эрсдэл гэдэг нь системийн доголдол, хувь хүний санамсаргүй болон санаатай үйлдэл болон бусад гадаад хүчин зүйлүүдийн улмаас Банк алдагдалд орж болох эрсдэл юм. Хяналт алдагдах үед үйл ажиллагааны эрсдэл нь нэр хүнд унах, хүүлийн болон зохицуулалтын асуудалд орох, улмаар санхүүгийн алдагдалд ороход ч хүргэж болно. Банк хэдийгээр үйл ажиллагааны эрсдлийг бүрэн арилгах бололцоогүй ч хяналт, мониторинг сайжруулах замаар энэ төрлийн эрсдлийг удирдаж болно. Хяналтад ажил үүргийн хуваарь, хяналттай системд нэвтрэх, түлган баталгаажуулах журмууд, боловсон хүчний боловсрол, үнэлгээний үйл явцууд багтана. Мөн дотоод аудиторын ажлыг ашиглах явдал орно.

### **32. Хөрөнгийн зохистой харьцаа**

Банк бизнесийн салшгүй эрсдлийг өөрийн хөрөнгөдөө тулгуурлан үр ашигтай удирддаг. Бусад арга хэмжээнүүдээс гадна Монголбанкнаас тогтоосон дүрэм, харьцаануудыг ашиглах замаар Банкны өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хянадаг.

##### **Капиталын удирдлага**

Монголбанк нь капиталын шаардлагыг Монголын нийт банкуудад тавьж, хянадаг.

Өөрийн хөрөнгөнд суурилан тооцсон өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцааг 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 12 хувиас багагүй (2016 оны 12 дугаар сарын 31: 12%) байлгахыг шаардсан бөгөөд 1 дүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө ба эрсдлээр жинлэсэн нийт хөрөнгө 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 9 хувиас багагүй байна (2016 оны 12 дугаар сарын 31: 9%).

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХХК  
Санхүүгийн Тайлангийн Тодруулга  
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

**32. Хөрөнгийн зохистой харьцаа (үргэлжлэл)**

**Капиталын удирдлага (үргэлжлэл)**

Тус банкны өөрийн хөрөнгийн зохистой харьцаа 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дараах байдалтай байна:

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<b>2017</b>	<b>2016</b>
1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө	45,422,642	9,463,529
2-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө	596	16,378
1 ба 2-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө	<b>45,423,238</b>	<b>9,479,907</b>
Эрсдлээр жинлэсэн актив	87,133,878	8,138,855
<b>Капиталын харьцаа</b>		
Эрсдлээр жинлэсэн активын хувиар илэрхийлсэн тохируулагч нийт капитал	52.13%	116.48%
Эрсдлээр жигнэсэн активын хувиар илэрхийлсэн нийт 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө	52.13%	116.28%

12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар эрсдлээр нь жигнэсэн активуудыг эрсдлийн ангилал тус бүрээр үзүүлбэл:

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<b>2017</b>		<b>2016</b>	
%	<b>Хөрөнгө</b>	<b>Эрсдлээр жигнэсэн</b>	<b>Хөрөнгө</b>	<b>Эрсдлээр жигнэсэн</b>
0	121,681,046	-	101,247	-
20	424,848	84,970	34,425	6,885
70	869,108	434,554	-	-
50	10,746,000	7,522,200	5,399,295	3,779,506
100	20,492,597	20,492,597	4,352,464	4,352,464
120	48,832,964	58,599,557	-	-
<b>Нийт</b>	<b>203,046,563</b>	<b>87,133,878</b>	<b>9,887,431</b>	<b>8,138,855</b>

**33. Орчуулга**

Эдгээр санхүүгийн тайлангууд нь Англи болон Монгол хэл дээр бэлтгэгдсэн бөгөөд Англи болон Монгол хувилбарын хооронд утга агуулгын зөрүү үүссэн тохиолдолд Англи хувилбар хүчин төгөлдөр байна.